# Аймаг, нийслэлийн хөгжлийн жилийн төлөвлөгөө

## Дорнод аймгийн Засаг даргын Тамгын газар

## 2022 оны жилийн эцэс

| Д/д | Зорилт | Арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Шалгуур үзүүлэлт | Хүрэх түвшин, үр дүн | Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг) | Хүрсэн түвшин, үр дүн | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1. КОВИД-19" ХАЛДВАРТ ЦАР ТАХЛААС ҮҮДЭЛТЭЙ ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ХҮНДРЭЛИЙГ ДАВАН ТУУЛАХ БОДЛОГО | | | | | | | | |
| 1 | 1.1.1.. "Ковид-19" халдварт цар тахлын үед иргэн, аж ахуйн нэгжийг дэмжих дараах арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ. | 1. Ажлын байраа хадгалах, орлоготой байх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор аж ахуйн нэгж, хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд хөдөлмөрийн аюулгүй байдал, ариун цэвэр, халдваргүйн горимыг хангах, мэдээлэл сурталчилгаа, нөлөөллийн ажлыг зохион байгуулна. | 2022 | Сургалт сурталчилгаа нөлөөллийн ажлын тоо, Мэдээлэл сурталчилгаанд хамрагдсан хүний тоо | 80, 25000 | | Хэрлэн сумын 11 багийн 144 хэсгийн ахлагч, улаан загалмайн 66 сайн дурын ажилтнуудтай гэрээ байгуулж, мэргэжил арга зүйгээр ханган, аж ахуйн нэгж, хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэдэд мэдээлэл, сургалт, сурталчилгааг зохион байгуулсан. Хэрлэн сумын Засаг даргын тамгын газар, Мэргэжлийн хяналтын газар, Цагдаагийн газар хамтран хүн ам олноор цуглардаг худалдаа, үйлчилгээ, хоол үйлдвэрлэл, үсчин, гоо сайхны газар, караоке, саун, кофе шоп, хүнсний дэлгүүр зэрэг 128 аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд халдвар хамгааллын дэглэм сахиулах, халдвараас урьдчилан сэргийлэх хяналтыг хийж, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлсэн. Коронавируст халдвар (Covid-19)-аас урьдчилан сэргийлэх | 70% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | чиглэлээр цахим хуудсанд давхардсан тоогоор 815 зөвлөмж байршуулан, хандалт 45762, давхардсан тоогоор 3127 төрлийн, 18621 ширхэг гарын авлага, зөвлөмжийг иргэдэд түгээсэн. | |
| 2 | | 2. Цахим суваг ашиглан КОВИД-19 шинэ болон сэргэн тархаж буй халдвараас сэргийлэхэд салбар дундын хамтын ажиллагааг нэмэгдүүлнэ. | 2022 | Байгууллагын тоо | 6 | | Аймгийн Онцгой комисс, шуурхай штабын Коронавируст халдвар (Covid-19)-аас урьдчилан сэргийлэх чиглэлээр гаргасан тогтоол, шийдвэр, Эрүүл мэндийн яам, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв, Эрүүл мэндийн газраас иргэдийг Коронавируст халдвар (Covid-19)-аас урьдчилан сэргийлэх мэдлэг, хандлагыг дээшлүүлэхээр боловсруулсан зөвлөмж, постерыг орон нутгийн хэвлэл мэдээллийн 6 телевиз, төрийн болон төрийн бус 24 байгууллага, орон нутгийн өмчит 12 аж ахуйн нэгжийн цахим хуудсуудаар иргэдэд түгээн, салбар дундын хамтын ажиллагааг нэмэгдүүлсэн. Хамтын ажиллагааны хүрээнд аймгийн Засаг даргын тамгын газар, Боловсрол, шинжлэх ухааны газар, Эрүүл мэндийн газар, Мэргэжлийн хяналтын газрын хамтарсан ажлын хэсэг Хэрлэн сумын 21 цэцэрлэг, 12 сургуулиудад халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, тандалтын багийн үйл ажиллагаа, цэвэрлэгээ халдваргүйтгэлд хяналт | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хийж мэргэжил арга зүйн зөвлөгөөг өгч, 674 багш ажилчид, 1747 хүүхэд, 2924 эцэг, эх, асран хамгаалагч нарт цахим болон танхимаар зөвлөгөө өгсөн. | |
| 3 | 1.1.2.. ”Ковид-19” халдварт цар тахлын эрсдэлээс урьдчилан сэргийлж, бэлэн байдлыг хангахтай холбоотой төсвийн санхүүжилтийг нэмэгдүүлнэ. | 1. Шинэ болон сэргэн тархаж байгаа халдвараас сэргийлэх, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хариу арга хэмжээний болон нөөцийн бэлэн байдлыг хангана | 2022 | Нөөцийн бэлэн байдал хангагдсан эрүүл мэндийн байгууллагын тоо | 19 | | Коронавируст халдвар (Covid-19)-ын цар тахлын эрсдэлээс урьдчилан сэргийлж, бэлэн байдлыг хангахтай холбоотой эрүүл мэндийн байгууллагууд коронавируст халдварын эмчилгээнд шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, хамгаалах хувцас хэрэгслийн нөөцийг бүрдүүлэн ажиллаж байна. Үүнд: вирусийн эсрэг эм 9 нэр төрөл, 39865 ширхэг, антибиотик эм 8 нэр төрөл, 44953 ширхэг, дуслын шингэн 8 нэр төрөл 2982, амилуулах тусламж үйлчилгээнд шаардлагатай эм бэлдмэл 4 нэр төрөл, 803 ширхэг, эмнэлгийн хэрэгсэл 13 нэр төрөл 109622 ширхэг, хувийн хамгаалах хэрэгсэл 16 нэр төрөл 297602 ширхэг, ПГУ ялгах 3047, тодорхойлох 2119, түргэвчилсэн тест шүлс 1925, хамар залгиур 1900 ширхэгийн нөөц бүрдүүлэн эмчилгээ, оношилгоонд хэрэглэж байна. | 100% |
| 4 | | 2. Зоонозын өвчин судлалын төв байгуулах саналыг нэгтгэн шийдвэр | 2022 | Авсан арга хэмжээний тоо | 1 | | Дорнод аймагт “Зоонозын өвчин судлалын төв” байгуулах хүсэлтийг Эрүүл мэндийн сайд С.Энхболд, УИХ-ын гишүүн Ц.Сэргэлэн, Зооноз | 70% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | гаргах түвшинд хүргүүлэх | | | | | өвчин судлалын үндэсний төвийн захирал, удирдлагуудад албан бичгээр хүргүүлсэн. Коронавирусийн халдвар зөөвөрлөгдөн орж ирэх эрсдэлийг үнэлэн аймгийн хэмжээнд 5 хилийн боомтын нэвтрэх цэгт тусгаарлах байр, ариутгалын пунктийг түр хугацаагаар байгуулан бэлэн байдлыг ханган ажиллаж байна. | |
| 5 | | 3. Зорилтот бүлгийн иргэдийг “Коронавируст халдвар”-ын дараах нөхөн сэргээх сувилалд хамруулна. | 2022 | Хамрагдсан иргэдийн тоо | 1350 | | Аймгийн Засаг даргын 2022 оны А/47 дугаар захирамжийн дагуу Коронавируст халдвар (Covid-19)-ын дараах зорилтот бүлгийн иргэдэд илэрч буй хам шинжийг эмчлэх, уушги төлжүүлэх, бие махбодийг тэгшитгэх, өвчний үлдэцийг арилгах, амьдралын чанарыг дээшлүүлэх зорилгоор Уламжлалт анагаах ухааны төв, хувийн хэвшлийн “Наран”, “Баянбүрд” мэдрэл, сэргээн засах үүдэн эмнэлэг, 13 сумын Эрүүл мэндийн төвүүдийг түшиглэн сэргээн засах зуны сувиллыг 2022 онд ажиллуулсан, хамрагдвал зохих зорилтот бүлгийн 1350 иргэнийг 100 хувь хамруулсан. | 100% |
| 2. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО | | | | | | | | |
| 6 | 2.1.1. . “Эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлэх дэд | 1. "Халдварт өвчинтэй тэмцэх сэргийлэх арга хэмжээ" | 2022 | Халдварт өвчний тохиолдол 10000 хүн амд ногдох тоо | 125 | | “Бэлгийн замаар дамжих халдвар болон сүрьеэ өвчнөөс урьдчилан сэргийлэх, тархалтыг бууруулах” төсөл арга хэмжээнд зорилтот | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | хөтөлбөр”-ийг хэрэгжүүлнэ | БЗДХалдвараас урьдчилан сэргийлэх, тархалтыг бууруулах төсөл хэрэгжүүлнэ. | | | | | бүлгийн 10000 иргэнийг хамруулахаар төлөвлөж, хамрагдалт 8100 буюу 81 хувьтай. Хэрлэн сумын эрсдэлт бүлгийн 900 гаруй иргэд, ерөнхий боловсролын сургуулийн 15-18 насны 1460 сурагч, Дорнод их сургууль, Политехникийн коллеж, Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн 755 оюутнууд, 10 төрийн байгууллагын 1000 гаруй албан хаагчид, уул уурхайн 370 ажилчин албан хаагчид, 13 сумын зорилтот бүлгийн 600 иргэдийг урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамруулж, тэмбүүгийн 11, заг хүйтний 10, трихоминиаз 16, мөөгөнцрийн 24, шээсний сувгийн үрэвсэлт 10 өвчлөлийг илрүүлэн, 100 хувь эмчилгээнд хамруулсан. Хавьтлын илрүүлэлт 85, хавьтлын эмчилгээ 80 хувь. 13 сумын зорилтот бүлгийн иргэдийн үзлэг шинжилгээ үргэлжилж байна. Нийт 20 төр, хувийн хэвшлийн 370 ажилтан, албан хаагч, 1460 сурагчид, Дорнод их сургууль, Политехникийн коллеж, Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн 755 оюутнуудад эрүүл мэндийн боловсрол олгох сургалт, нөлөөллийн ажлыг зохион байгуулж, сурталчилгааны 3000 ширхэг гарын авлага түгээсэн. | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 7 | | 2. "Халдварт өвчинтэй тэмцэх сэргийлэх арга хэмжээ" Сүрьеэ өвчнөөс урьдчилан сэргийлэх, тархалтыг бууруулах төсөл хэрэгжүүлнэ. | 2022 | Халдварт өвчний тохиолдол 10000 хүн амд ногдох тоо | 10 | | Сүрьеэ өвчний 48 тохиолдол шинээр бүртгэгдэж, 10 000 хүн амд 5,7 байгаа нь өмнөх оны мөн үеэс 0,9 промилиор нэмэгдсэн байна. Сүрьеэгийн хавьтлын болон эрт илрүүлэг үзлэгт нийт 3092 иргэнийг хамруулж, сэжигтэй 111 иргэнээс сорьц тээвэрлэн сүрьеэгийн 4 шинэ тохиолдлыг илрүүлэн эмчилгээнд хамруулаад байна. “Сүрьеэ өвчин, түүнээс урьдчилан сэргийлэх” сэдвээр төрийн 15 байгууллага, аж ахуйн нэгж, сургууль, цэцэрлэгийн 500 ажилтан, албан хаагч, хүүхдүүдэд сургалт зохион байгуулж, гарын авлага түгээсэн. Тэмбүү өвчин өмнөх оны мөн үеэс 46 тохиолдлоор буурч, заг хүйтэн 129 трихоминиаз 180 тохиолдлоор нэмэгдсэн. | 100% |
| 8 | | 3. Дархлаажуулалтын үйл ажиллагааг өргөжүүлж, томуугийн вакцинд хамруулна. | 2022 | Вакцинд хамрагдсан хүүхдийн тоо, Дархлаажуулалтын хувь | 99,4, 99,4 | | Товлолын дархлаажуулалтын хамралт 98,8 хувьтай. Орон нутгийн хөгжлийн сангийн дэмжлэгтэйгээр зорилтот бүлгийн 1-4 насны 2000, сайн дурын дархлаажуулалтад 100, тархвар судлалын заалтаар жирэмсэн, 65 дээш архаг суурь өвчтэй, эрүүл мэндийн байгууллагын ажилтан, 3-12 насны тус тус 11718 иргэн, нийт 13818 хүнийг томуугийн дархлаажуулалтад хамруулж өмнөх оноос 1550 иргэнээр нэмэгдсэн. | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 9 | | 4. Суурь өвчлөлтэй болон зорилтот бүлгийн хүүхдүүдийг зуны сувилалд хамруулах ажлыг үргэлжлүүлнэ | 2022 | Сувилалд хамрагдсан хүүхдийн тоо | 400 | | Зорилтот бүлгийн болон суурь өвчлөлтэй хүүхдүүдийн зуны сувиллыг 14 суманд ажиллуулах 2 багц бүхий ажлын даалгаврын дагуу 13 суманд сумын эрүүл мэндийн төвийг, Хэрлэн суманд “Их нандин групп” ХХК-ийг түшиглэн хоол тэжээлийн хурц болон архаг дутагдлаас үүдэлтэй сульдаа, жингийн алдагдал, цус багадалттай 400 хүүхдүүдийг зуны сувилалд 100 хувь хамруулсан. | 100% |
| 10 | | 5. Сумын ахмадуудыг өдрийн сувилалд хамруулах | 2022 | Сувилалд хамрагдсан ахмадын тоо | 810 | | Хөдөөгийн 13 сумын Эрүүл мэндийн төвийг болон орон нутаг дахь амралт сувиллын газрыг түшиглэсэн ахмад настны зуны сувилалд нийт 810 ахмад настныг (100%) хамруулж, сэргээн засах эмчилгээ, эрүүл хооллолт, эмийн эмчилгээ, эрүүл мэндийн боловсрол олгох сургалт, дасгал хөдөлгөөнөөр эрүүлжүүлсэн. Орон нутгийн төсвийн 27,0 сая төгрөгийн санхүүжилтээр 4 дэх жилдээ хэрэгжсэн сувиллын үр дүнд нийт ахмад настны 87,0 хувьд нь артерийн даралт тогтмолжсон, 88,1 хувьд нь нойргүйдэл багассан, 86,0 хувьд нь эрхтэн системийн хавсарсан зовуурь болон өвдөлт багассан, сэтгэл зүйн байдал болон хөдөлгөөний идэвхэд ахиц гарч, эрүүл мэндийн боловсрол дээшилсэн, ахмад настанд чиглэсэн эмнэлгийн тусламж, үйлчилгээний | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хүртээмж нэмэгдсэн үр дүнтэй байна. | |
| 11 | | 6. Оюутны эрүүл мэндийг дэмжих "Эрүүл оюутан төсөл" хэрэгжүүлнэ. | 2022 | Төслийн хэрэгжилтийн хувиар | 100 | | Орон нутгийн төсвийн 20 сая төгрөгийн санхүүжилтээр аймгийн Засаг даргын А/41 дүгээр захирамжийн дагуу Дорнод их сургууль, Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв, Политехник коллежийн 755 оюутнуудыг 6 төрлийн нарийн мэргэжлийн эмчийн үзлэгт хамруулж, үзлэгт давхардсан тоогоор 937 өвчлөл (чих, хамар хоолойн өвчлөл 200, нүдний өвчин 199, шүдний өвчлөлтэй 495, бэлгийн замын дамжих халдвартай 21, сүрьеэгийн илрүүлгийн асуумжид гэр бүл болон ойрын хавьтлын өгүүлэмжтэй 12) илэрсэн ба 65,5 хувийг нь шүдний өвчлөл эзэлж байна. Супердент, Family smile, БЭСУ, Гандент шүдний хувийн эмнэлгүүдтэй 18 сая төгрөгийн гэрээ байгуулж, шүдний өвчлөлтэй 1, 2 дугаар дамжааны 200 оюутны амны хөндийг бүрэн эмчлэн эрүүлжүүлсэн. Мөн 702 оюутнуудад халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэгт хамрагдахын ач холбогдлын талаарх танхимын сургалт зохион байгуулж, 4 төрлийн сурталчилгааны материалыг 300 хувь хэвлүүлэн түгээж, 45 оюутныг | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | “Оюутан сургагч багш”-аар бэлтгэсэн. | |
| 12 | | 7. "Аз жаргал" төвийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлнэ. | 2022 | Төвөөр үйлчлүүлсэн хүүхдийн тоо | 1600 | | Аймгийн Засаг даргын 2022 оны А/19 дугаар захирамжаар “Аз жаргал төв”-ийн үйл ажиллагааг “Ашид батжин” ТББ сонгогдон ажил гүйцэтгэх гэрээ байгуулан 25,0 сая төгрөгийн санхүүжилтийг олгоод байна. “Аз жаргал” төвөөр нийт 4106 өсвөр насны хүүхдүүдэд нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 28,0 хувиар нэмэгдсэн. | 100% |
| 13 | | 8. "Эх хүүхэд нөхөн үржихүйн эрүүл мэнд арга хэмжээ" Эрүүл эмэгтэй төслийг хэрэгжүүлнэ. | 2022 | 100 | 100 | | Аймгийн Засаг даргын 2022 оны А/35 дугаар захирамжаар нөхөн үржихүйн 19-40 насны эх барихын ужиг дурдатгалтай эмэгтэйчүүд болон өртөмтгий бүлгийн жирэмсэн 180 эмэгтэйчүүдийг TORCH халдварын шинжилгээнд хамруулах 25 сая төгрөгийн санхүүжилт бүхий төсөл арга хэмжээг батлуулан, шинжилгээнд хамрагдах эхчүүдийн судалгааг хийж дуусаад байна. Эрүүл эмэгтэй худалдан авах ажиллагаа дахин техникийн үзүүлэлт, тоо хэмжээг өөрчлөн тендер зарлаж, “Илдэн Гүн” ХХК шалгарсан ба 45 хоногийн хугацаанд нийлүүлэлт хийгдэнэ. | 100% |
| 14 | | 9. "Эх хүүхэд нөхөн үржихүйн эрүүл | 2022 | Төсөлд хамрагдсан эхчүүдийн тоо | 1000 | | Аймгийн Засаг даргын 2022 оны А/35 дугаар захирамжаар | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | мэнд арга хэмжээ" Эхчүүдээ хайрлая төслийг хэрэгжүүлнэ. | | | | | удирдамж, төсөв батлагдан хэрэгжиж эхэлсэн “Эрүүл эмэгтэй” төслийн хүрээнд аймгийн хэмжээнд нөхөн үржихүйн 31-40 насны 1000 эмэгтэйчүүдийг В вирусийн эсрэг дархлаажуулалтын 1, 2, 3 дугаар тунд нийт 982 эмэгтэйчүүдийг хамруулсан. | |
| 15 | | 10. Эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлэх дэд хөтөлбөрийн хүрээнд орон нутагт ажиллаж буй эмнэлгийн мэргэжилтнүүдийг тогтвор суурьшилтай ажиллахад дэмжлэг үзүүлэх | 2022 | Дэмжлэгт хамрагдсан эмч, эмнэлгийн мэргэжилтний тоо | 78 | | “Эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлэх” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд анхан шатны эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн тогтвор суурьшилтай ажиллах, мэдлэг ур чадварыг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор 39,0 сая төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангаас 13 сумын эрүүл мэндийн төвийн 78 сувилагчид тус бүр 500 мянган төгрөгийг олгосон. | 100% |
| 16 | | 11. "Би сувилагч" төсөл хэрэгжүүлнэ | 2022 | Төсөлд оролцогчдын тоо | 40 | | Орон нутагт анх удаа “Би сувилагч” төсөлт уралдаан аймгийн Засаг даргын 2022 оны А/222 дугаар захирамжид заагдсан удирдамжийн дагуу 3 үе шаттай зохион байгуулагдаж, шалгарсан 3 сувилагчид орон орон сууц худалдан авах байрны урьдчилгаанд тус бүр 20,0 сая төгрөгийн дэмжлэг, шилдэг оролцогч болсон бусад 9 сувилагч нарт тус бүр 400 мянган төгрөгийн урамшуулал олгосон. | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 17 | | 12. Элэгний В вирусын халдваргүй нярай төслийг үргэлжлүүлж дархлал тогтоцыг үнэлэх ажлыг зохион байгуулна. | 2022 | Вакцинд хамрагдсан нярайн тоо | 100 | | “Монгол Эм Импекс концерн” ХХК-тай гэрээ байгуулж, 2022 онд дархлаажуулах 100 хүн тун иммуноглобулиныг хүлээн авсан. Элэгний “В” вирусын халдвартай эхээс төрсөн 78 нярайг ммуноглобулин(HBIG)-ээр дархлаажуулж, халдварыг таслан сэргийлсэн байна. | 100% |
| 18 | | 13. "Эрчүүдийн эрүүл мэндийг хамгаалах хөтөлбөр” төсөл хэрэгжүүлэх /эрэгтэйчүүдэд зөвлөгөө өгөх кабинет байгуулах/ | 2022 | Кабинет байгуулсан эсэх | 1 | | Хэрлэн сумын зорилтот бүлгийн 20 иргэнийг архины хор хөнөөлийн талаарх сургалтад хамруулан, архинаас татгалзах эмчилгээг эхлүүлээд 7,7 сая төгрөгийг зарцуулаад байна. Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн Сэтгэцийн эрүүл мэндийн тасагт Сэтгэл заслын үйлчилгээ үзүүлэх тусгай танхимд шаардлагатай 5,7 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг худалдан авахаар “Дорнын мандан бадархуй” ХХК-тай гэрээ хийж, аймгийн Засаг даргын 2022оны А/502 захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг тус тоног төхөөрөмжийг хүлээн авч, ашиглалтад оруулаад байна. | 100% |
| 19 | | 14. "Халдварт бус өвчнөөс сэргийлэх" арга хэмжээний хүрээнд харшлаас сэргийлэх ажил зохион байгуулах | 2022 | Суурь судалгааг эхлүүлэх | 1 | | “Харшлаас сэргийлэх“ төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхэд ургамлын тоосонцорын харшилтай 200 иргэнийг сорилд хамруулахаар “Эрдэнийн Очир уянга” ХХК-ийн “Derma med” арьс харшил, гоо заслын хувийн хэвшлийн үүдэн | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | эмнэлэгтэй хамтран ажиллах гэрээ хийгдээд гүйцэтгүүлж байна. | |
| 20 | | 15. Эрүүл мэндийг дамжигч байгууллага шалгаруулах болзолт уралдааныг зохион байгуулна | 2022 | Дэмжигч байгууллагын тоо | 5 | | “Эрүүл мэндийг дэмжигч байгууллага”-ын зэргийг ахиулах, тоог нэмэгдүүлэх, улмаар улсын гэрчилгээний болзлыг хангуулахаар төсөлт арга хэмжээг баталсан. Эрүүл мэндийн анхан шатны 6 байгууллага, Хэрлэн сумын 9, 11 дүгээр цэцэрлэг, ерөнхий боловсролын 1 сургуулийн багш, эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтнуудад “Эрүүл мэндийг дэмжигч байгууллага”-ын ач холбогдол, хэрхэн дэмжигч байгууллага болох талаар сургалт, зөвлөгөө өгч, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлсэн. Эрүүл мэндийн даатгалын байгууллагын шалгаруулалтын материалыг хүртэл хүлээн авч, үнэлгээ хийн, 12 дугаар сард шалгаруулан өргөмжлөл, мөнгөн шагналыг гардуулна. Улсын тэргүүний 14 дүгээр цэцэрлэг Эрүүл мэндийн яаманд 2 дугаар шатны шалгаруулалтад материалаа хүргүүлж үнэлгээний шатандаа явж байна. | 100% |
| 21 | | 16. Зүрх судасны өвчлөлөөс сэргийлэх МОНПЕН санаачилгыг нутагшуулна | 2022 | Төсөлд хамрагдсан иргэдийн тоо | 8000 | | Халдварт бус өвчин/Зүрх судасны өвчнөөс урьдчилан сэргийлэх Монпен төслийн хүрээнд 18-аас дээш насны иргэдийг артерийн гипертензи, чихрийн шижин өвчнийг | 70% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | эрт илрүүлэг үзлэгт хамруулахад шаардагдах оношлуурт зарцуулагдах санхүүжилтэд Орон нутгийн хөгжлийн сангаас 42,1 сая төгрөгийн дэмжлэг бүхий тендерийг зохион байгуулж, "НДАБ" ХХК шалгарч оношлуурыг хүлээлгэн өгч, ашиглалтад оруулаад байна. Анхан шатны эрүүл мэндийн байгууллагууд өөрсдийн нөөц бололцоонд тулгуурлан үзлэг оношилгоог тасралтгүй хийж байгаа бөгөөд зорилтот насны иргэдийн 32,7 хувийг хамруулж, шинээр артерийн даралт ихдэлт 1048, чихрийн шижин 99 өвчлөл илрүүлж хяналтдаа аваад байна, "НДАБ" ХХК оношлуурын гэрээ сунгагдсан. | |
| 22 | | 17. "Сургууль, цэцэрлэгийн эмч ба Эрүүл мэнд" төсөл хэрэгжүүлнэ. | 2022 | Төсөлд хамрагдсан сургууль, цэцэрлэгийн тоо | 62 | | Ерөнхий боловсролын 26 сургуульд 11, 36 цэцэрлэгт 10 нэр төрлийн 47,6 сая төгрөгийн багаж, тоног төхөөрөмжийг нийлүүлэх гүйцэтгэгчээр "Сүвэн-Уул" ХХК шалгарч, гэрээний хугацаанд багаж тоног төхөөрөмжийг нийлүүлсэн. | 100% |
| 23 | 2.1.2. . Эмнэлгүүдийн барилга байгууламж, дэд бүтцийг сайжруулан стандарт, чанарын шаардлага | 1. Эрүүл мэндийн байгууллагуудын дэд бүтцийг сайжруулан стандарт, чанарын шаардлага хангасан тэгш хүртээмжтэй, чанартай үйлчилгээг | 2022 | Шинээр баригдсан эрүүл мэндийн барилга, байгууламжийн тоо, Засвар хийгдсэн эрүүл мэндийн байгууллагын тоо | 3, 4 | | Хүүхдийн 200 ортой 9,5 тэрбум төгрөгийн өртөг бүхий шинэ эмнэлгийн барилгын ажил 2021 оны 08 дугаар сард эхэлсэн бөгөөд гүйцэтгэгчээр "Ихбазар констракшн" ХХК ажиллаж байна. Хүүхдийн эмнэлгийн барилгын инженерийн шугам сүлжээ, дотоод заслын 2.3 тэрбум төгрөгийн ажлын худалдан | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | хангасан тэгш хүртээмжтэй, чанартай үйлчилгээ үзүүлэх орчныг бүрдүүлнэ. | үзүүлэх орчин бүрдүүлнэ. | | | | | авах ажиллагаа зохион байгуулагдаж, гүйцэтгэгчээр "Ихбазар констракшн" ХХК шалгарсан. Барилгын гүйцэтгэл 2021 онд 2,1 тэрбум төгрөгөөр А блокын 4 давхар хүртлэх карказын ажил, 2022 онд 676,0 сая төгрөгөөр В блокын суурийн ажил, А блокын дээврийн караказын ажлыг тус тус хийж гүйцэтгэсэн байна. Улсын төсвийн 1,5 тэрбумын хөрөнгө оруулалтаар Баянтүмэн сумын эрүүл мэндийн төвийн барилгын ажил 2022 оны 5 дугаар сард эхэлж, 2022 оны 9 сард ашиглалтад хүлээн авч, үйл ажиллагаа нь явагдаж эхэлсэн. Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн 450,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих Хэрлэн сумын алслагдсан 2, 3 дугаар багийн нутаг дэвсгэрт баригдах Өрхийн эрүүл мэндийн төвийн салбар шинээр барих барилгын ажлын гүйцэтгэгчээр "Дорнын танан өргөө" ХХК шалгарч, барилга 2022 оны 10 дугаар сард ашиглалтад орсон. Аймгийн Орон нутгийн төсөв, Орон нутгийн хөгжлийн сангийн 291,2 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 2022-2023 онд хэрэгжих Булган сумын эхийн амрах байрны барилгын ажлын гүйцэтгэгчээр "Донж өргөө" ХХК шалгарч, барилгын ажил эхэлсэн бөгөөд 2023 онд ашиглалтад орно. | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Аймгийн Орон нутгийн төсөв, Орон нутгийн хөгжлийн сангийн 442,8 сая төгрөгөөр 5 сумын эрүүл мэндийн төвд засвар хийгдэхээр төлөвлөгдсөнөөс Чойбалсан, Хөлөнбуйр, Баяндун, Чулуунхороот сумын Эрүүл мэндийн төвүүдийн засварын ажил бүрэн дуусаж ашиглалтад хүлээн авсан. Сэргэлэн сумын Эрүүл мэндийн төвийн ариун цэврийн байгууламжийн засварын ажлын худалдан авах ажиллагаа 4 удаа зохион байгуулагдаж, оролцогч санал ирүүлээгүй шалтгаанаар амжилтгүй болсон. | |
| 24 | | 2. Эрүүл мэндийн байгууллагуудыг нэн шаардлагатай орчин үеийн техник, тоног төхөөрөмжөөр үе шаттай хангана. | 2022 | Техник, тоног төхөөрөмжөөр хангагдсан эрүүл мэндийн байгууллагын тоо | 6 | | Эрүүл мэндийн байгууллагуудын тоног төхөөрөмж, багаж, хэрэгсэл нийлүүлэхээр аймгийн орон нутгийн хөгжлийн сангаас 321,3 сая төгрөг батлагдсан. 2 сумын эрүүл мэндийн төвд 44,9 сая төгрөгийн шүдний кабинетын багаж, тоног төхөөрөмж, НЭМТөв болон БОЭТөвд 49,0 сая төгрөгийн сургалтын тоног төхөөрөмж, тавилга нийлүүлэгдээд байна. | 70% |
| 25 | 2.1.3. . Хөдөөгийн хүн амд төрөлжсөн тусламж үйлчилгээг хүргэх “Хөдөлгөөнт | 1. Нийгмийн цогц явуулын үйлчилгээ /эрүүл мэнд, хүүхэд хамгаалал, хөдөлмөр эрхлэлт, соёл, ахуй үйлчилгээ/ | 2022 | Тусламж үйлчилгээ авсан иргэдийн тоо | 12000 | | Аймгийн Засаг даргын 2022 оны А/23 захирамжаар хэрэгжиж буй “Нийгмийн цогц явуулын үйлчилгээ” 2022 оны 06 дугаар сараас эхлэн өнөөдрийг хүртэл 13 сумдад ажиллаж, нийт 5048 иргэнийг төрөлжсөн мэргэжлийн эмчийн үзлэгт хамруулснаас дотор 935, | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | эмнэлэг" ажиллуулна. | | | | | | эмэгтэйчүүд 491, эхо 1241, хүүхэд 202, нүд 330, шүд 1214, чих, хамар хоолой 635 иргэнд хүрч үйлчилсэн байна. Эрүүл мэнд, хүүхэд хамгаалал, хөдөлмөр эрхлэлт, соёл, ахуй үйлчилгээ зэрэг нийгмийн цогц явуулын үйлчилгээнд нийт 12373 иргэд үйлчлүүлсэн байна. Явуулын цогц тусламж үйлчилгээний автобусыг худалдан авах, тусламж үйлчилгээ үзүүлэхэд шаардагдах нийт 92,0 сая төгрөгийг орон нутгийн төсвийн санхүүжилтээр шийдвэрлэсэн байна. | |
| 26 | 2.1.4.. Гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн аргыг эрүүл мэндийн байгууллагуудад нэвтрүүлнэ. | 1. Эрүүл мэндийн байгууллагуудыг гүйцэтгэлд суурилсан санхүүжилтэнд үе шаттай шилжүүлнэ. | 2022 | Санхүүжилтийг шилжүүлсэн эсэх | 15 | | Эрүүл мэндийн байгууллагуудыг гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийг 100 хувь шилжүүлсэн. | 100% |
| 27 | 2.1.5.. Шаардлагатай сум, багт төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны хүрээнд эмийн сангийн үйлчилгээг хүргэнэ. | 1. Төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд аймаг сумын төвийн алслагдсан багуудад эмийн сан ажиллуулна. | 2022 | Алслагдсан багт байршилтай эмийн сангийн тоо | 4 | | Аймгийн төвөөс алслагдсан Хэрлэн сумын 2, 8 дугаар багт үйл ажиллагаа эрхэлж байгаа "Тун фарм", "Батраш" эмийн сангийн эрхлэгч нартай 2022 оны гэрээг шинэчлэн байгуулж, эхний хагас жилийн түрээсийн санхүүжилт олгох санхүүгийн баримт бичгийг бүрдүүлэн олгосон. Эмийн сангийн дотоод үйл ажиллагаанд стандартын хэрэгжилтийн дэмжлэгт | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хяналтыг 1 удаа хийж, коронавируст халдвар болон томуугийн өвчлөлтэй холбоотой шаардлагатай мэдээ тайланг тухай бүр авч, мэдээллээр хانган ажиллаж байна. | |
| 28 | 2.1.6. . Эрүүл мэндийн салбарын ажилтан, албан хаагчдын нийгмийн хамгааллыг дэмжин, нэн шаардлагатай мэргэжлээр эмнэлгийн мэргэжилтнийг бэлтгэн чадавхжуулна | 1. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний эрэлтэд суурилсан нэн шаардлагатай эмч мэргэжилтнээр үе шаттай хангана. | 2022 | Шинээр бэлтгэгдсэн эмч мэргэжилтний тоо | 21 | | Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний эрэлтэд суурилсан нэн шаардлагатай мэргэжил болох төрөлжсөн, мэргэжил дээшлүүлэх сургалтад сум, өрхийн эрүүл мэндийн төвүүд, Бүсийн оношилгоо, эмчилгээний төв, Уламжлал анагаах ухааны төвийн 16 эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд хамрагдан суралцаж байна. | 100% |
| 29 | 2.2.1. Хүн амыг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, эрүүл амьдралыг дэмжсэн идэвхтэй дасгал хөдөлгөөн, явган аялал, дугуйн спорт зэрэг спортын клубүүдтэй | 1. "Үндэсний бөхийн спортыг хөгжүүлэх хөтөлбөр", Үндэсний сурын спортыг хөгжүүлэх үйл ажиллагааг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ. | 2022 | Хэрэгжилтийн хувиар | 100 | | Улс, аймаг, сум, нэрэмжит бөхийн 16 барилдаан болон өсвөрийн бөхийн 3 удаагийн барилдааныг зохион байгуулж 1564 тамирчдыг хамруулсан. Өсвөрийн барилдаанд 6 насны ангилалд 11 багийн 140 гаруй сурагчид, 4-5 настай хүүхдүүдийн дунд зохион байгуулсан “Аваргын гараа” үндэсний бөхийн барилдаанд 88 хүүхэд, Даншгийн алдарт бөх Хүдэр даян аваргын нэрэмжит үндэсний бөхийн өсвөр үеийн аварга шалгаруулах анхдугаар тэмцээнд | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | хамтран ажиллана. | | | | | | 229 өсвөрийн бөхчүүд тус тус барилдсан. Хөтөлбөрийн хүрээнд батлагдсан төсвөөс 9,1 сая төгрөг зарцуулсан. Үндэсний сурын аймгийн нээлтийн харваанд 5 төрөлд давхардсан тоогоор 107 харваач, Үндэсний спортын VII наадмын анхан шатны сурын харвааг 3 төрлөөр зохион байгуулж, 100 харваач, улсын нээлтийн харваанд Дорнод аймгаас 50 харваач, аймгийн Засаг даргын нэрэмжит насанд хүрэгчдийн Үндэсний их сурын цуваа харваанд 50 харваач, Аймгийн хаалтын харваанд 90 харваач тус тус оролцсон. Ардын хувьсгалын 100, 101 жилийн ойн баяр наадамд Дорнод аймгийн харваачид амжилттай оролцож, Булган сумын уугуул, спортын мастер А.Цэвэлмаа Монгол Улсын Тод харваач цол хүртсэн. Үндэсний спортын VII наадмын шигшээ тэмцээнд үндэсний сурын харвааны төрөлд хүрэл медаль хүртсэн. Батлагдсан төсвөөс 10,0 сая төгрөг зарцуулсан байна. | |
| 30 | | 2. Нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх, хүүхэд залуусыг багийн спортоор тогтмол хичээллүүлэх чиглэлээр спортын | 2022 | Хэрэгжилтийн хувиар | 80 | | “Илүүдэл жингүй-Эртэч Монгол” аянд төрийн 7 байгууллага, төрийн тусгай 2 байгууллага, 8 сум, сургуулийн өмнөх боловсролын 4, нийт 13 байгууллага давхардсан тоогоор 37000 гаруй албан хаагч, иргэд идэвхтэй оролцсон. Аяны | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | клубын үйл ажиллагааг дэмжиж ажиллана. | | | | | хүрээнд аж ахуйн нэгж байгууллагын дунд спортын 12 удаагийн арга хэмжээнд давхардсан тоогоор 3400 гаруй оролцогчид хамрагдсан. Мөн “Эртэч Дорнодчууд” бүх нийтийн хөдөлгөөн арга хэмжээг 6, 7, 8 дугаар сард зохион байгуулсан. Тус арга хэмжээнд  “Дорнод аймгийн Дугуйн холбоо”, “Дорнод Найрамдал Зумба”, Хэрлэн сумын 7дугаар багийн “Хийн дасгал” хамт олон болон төрийн байгууллагын албан хаагчид нийт 150 иргэнийг хамруулсан. Монголын бүх ард түмний XV наадмын анхан шатны тэмцээнийг Дорнод аймагт спортын 6 төрлөөр зохион байгуулж, нийт 740 гаруй тамирчид оролцсон. Аймаг орон нутгаас баг, тамирчдын зардалд 8,0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Аймгийн аварга шалгаруулах 14 удаагийн тэмцээнийг зохион байгуулж 1892 гаруй тамирчид оролцов. Дорнод аймгийн хөдөөгийн сумдын залуучуудын урлаг, спортын V дугаар бага наадам олон төрөлт (волейбол, олс таталт, үндэсний бөх, буриад сурын харваа, мини хөлбөмбөг, марш гүйлт) зохион байгуулагдаж, 13 сумын 273 тамирчид өрсөлдсөн. “Хуримтлалтай Дорнодчууд” 2022 | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | бүх нийтийн гүйлтийг зохион байгуулж, 320 тамирчид оролцсон. | |
| 31 | | 3. Өвлийн спортын төрлийн хөгжүүлэх, зориулалтын талбай орчин нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр аж ахуйн нэгж, байгууллагатай хамтран ажиллана. | 2022 | Хэрэгжилтийн хувиар | 80 | | Мөсөн шагайн холбоо байгуулж, аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулсан. Дорнод аймагт Мөсөн шагайн Монгол Улсын шүүгчтэй болсон. Үндэсний спортын өвлийн наадамд мөсөн шагай, мөсөн сурын харваа төрлөөр 16 тамирчин амжилттай оролцсон. | 70% |
| 32 | 2.2.2. Шилдэг баг тамирчдыг бэлтгэх, тэдний залгамж холбоог тасралтгүй үргэлжлүүлэх зорилгоор аймгийн Хүүхдийн төлөө зөвлөл нь спортын зарим төрлүүдээр “Өсвөрийн шигшээ” баг байгуулж, дэмжиж ажиллана. | 1. Биеийн тамир спортын уралдаан тэмцээн зохион байгуулах, олон улс болон бүсийн чанартай уралдаан тэмцээнд оролцоход дэмжлэг үзүүлнэ. | 2022 | Дэмжлэг үзүүлсэн тамирчдын тоо | 800 | | Дорнод аймгаа төлөөлөн баг, тамирчид 5 удаагийн спортын наадам, 25 удаагийн улсын аварга, 6 удаагийн бүсийн аварга шалгаруулах тэмцээнд 700 гаруй тамирчин оролцож, 80 алт, 76 мөнгө, 103 хүрэл, нийт 259 медаль хүртэж, тэмцээнд оролцогдчын 38 хувь нь медалийн болзол хангасан. Аймгийн аварга шалгаруулах 15 удаагийн тэмцээнийг зохион байгуулж, 1892 гаруй тамирчид оролцсон. Тэмцээнд оролцсон тамирчдын зам, байр, хоолны зардалд орон нутгийн төсвийн хөрөнгөөс 41,0 сая төгрөг зарцуулагдсан. | 90% |
| 33 | | 2. Шилдэг баг тамирчдыг бэлтгэх "Өсвөрийн шигшээ баг" байгуулж, үйл | 2022 | Өсвөрийн шигшээ багийн тоо | 5 | | Дорнод аймгийн “Өсвөрийн шигшээ баг”-ийг спортын 3 (хөнгөн атлетик, бокс, жүдо бөх) төрлөөр байгуулж, тамирчид улс, бүсийн чанартай тэмцээнүүдэд амжилттай оролцон | 90% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | ажиллагаанд дэмжлэг үзүүлнэ. | | | | | 48 алт, 35 мөнгө, 45 хүрэл медаль аваад байна. Батлагдсан төсвөөс хөнгөн атлетикийн шигшээ багт 1,2 сая төгрөг, боксын шигшээ багт 1,1 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. | |
| 34 | 2.3.1. Хүн бүрт чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, боловсролын чанарыг дээшлүүлэн, үндэсний хэмжээнд өрсөлдөх чадвартай хүний нөөцийг бэлтгэнэ. | 1. Багшийн хөгжлийг дэмжих аймгийн “Эрдэм” хөтөлбөр (2021-2024 он)-ийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ. | 2022 | Хөтөлбөрт хамрагдалтын хувиар | 100 | | “Эрдэм” хөтөлбөрийн хүрээнд багшийн мэргэжил, ур чадвар, арга зүйг сайжруулахад дэмжлэг үзүүлэх 8 удаа сургалт зохион байгуулж, 450 багш, удирдах ажилтан, ажлын байран дээр мэргэжил дээшлүүлэх 113 сургалтад цэцэрлэг, сургуулийн 1370 багшийг 100 хувь хамруулсан. Боловсрол, шинжлэх ухааны газрын дэргэдэх “Зөвлөх” мэргэжлийн зэрэгтэй багш, сургалтын менежер, захирлын бүрэлдэхүүнтэй “Зөвлөх баг”-ийг байгуулан 2 сумын сургууль, цэцэрлэгт зөвлөн тусалж, удирдах ажилтны арга барил, багш нарт тулгамдаж буй заах арга, харилцаа хандлагын чиглэлээр сургалт зохион байгуулсан. Ерөнхий боловсролын сургуулийн багш нарын 65,6 хувь нь мэргэжлийн зэрэгтэй багш ажиллаж байгаа ба энэ нь өмнөх оноос 5,6 хувь, Зөвлөх багш 1,4 хувь, Тэргүүлэх багш 2,7 хувь, Заах аргач багш 2,4 хувиар, цэцэрлэгийн багш нарын 34,8 хувь мэргэжлийн зэрэгтэй буюу өмнөх оноос 10 хувиар, Зөвлөх багш 0,4 хувиар, Тэргүүлэх багш 1,2 хувь, Заах аргач багш 7,2 хувиар тус тус | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | өссөн үзүүлэлттэй байна. Бага ангийн шилдэг 4 багшийг шалгаруулж, урамшуулах 80,0 сая төгрөгийн шагналын сантай “Дорнодын багш” болзолт уралдааныг зохион байгуулж, 4 багшид тус бүр орон сууц худалдан авахад 20,0 сая төгрөг, 8 багш, ажилтанд эрүүл мэнд, түрээсийн байрны төлбөр, сургалтын төлбөрийн дэмжлэгт нийт 6,0 сая төгрөгийн буцалтгүй тусламж олгосон. Тус хөтөлбөрийн үр шимийг ерөнхий боловсролын 26 сургууль, 35 цэцэрлэг, Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв, Политехник коллежийн багш нар 100 хувь хүртэж байна. | |
| 35 | | 2. Аймаг болон боловсролын салбарын зорилтот жилийн арга хэмжээг хэрэгжүүлнэ. | 2022 | Хэрэгжилтийн хувиар | 100 | | Дорнод аймаг 2022 оныг “Ес зүйг дээдлэх жил”, боловсролын салбар “Ёс зүй-Манлайлал-Боловсрол” зорилтот жил болгон зарласан. Зорилтот жилийн хүрээнд Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, насан туршийн боловсролын төвийн багш, удирдах ажилтан болон бусад ажилтны ёс зүйн аймгийн зөвлөл нь 7 зорилт, 20 арга хэмжээг төлөвлөн 100 хувь хэрэгжүүлэн ажилласан. Үүнд: Багш удирдах болон бусад ажилтнуудад ёс зүй, хүүхдийг эерэг аргаар хүмүүжүүлэх арга зүйн 2 удаагийн сургалт, 14 нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулж, | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | сургууль, цэцэрлэгийн багш, удирдах ажилтнуудыг 100 хувь хамруулж, 9 багш, удирдах ажилтанд 4 удаагийн мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлсэн. Мөн хөдөөгийн 13 сумын сургууль, цэцэрлэг тус бүрт сургалт, хэлэлцүүлэг, нөлөөллийн ажил, ганцаарчилсан зөвлөгөө өгөх үйл ажиллагааг зохион байгуулж, 1026 багш, ажилтан, 2210 эцэг эх, 9350 суралцагчийг хамруулсан. Багш ажилтан, эцэг эхийн төлөөлөл 1200 хүнээс сэтгэл ханамжийн судалгааг авсан ба 16 сургууль, 18 цэцэрлэгийн хамгийн их доголдож буй асуудлаа олж харж, засан сайжруулахад анхаарч ажилласан. Аймгийн ёс зүйн зөвлөлд 2 өргөдөл ирснийг хугацаанд нь шийдвэрлэн ажилласан. | |
| 36 | | 3. "ЭЕШ-2022" эрчимжүүлсэн сургалт зохион байгуулж, амжилт үзүүлсэн багш, сурагчдыг урамшуулна. | 2022 | Амжилттай оролцсон сурагчдын хувиар | 90 | | Элсэлтийн ерөнхий шалгалтын эрчимжүүлсэн сургалтад Физик, түүх, нийгмийн ухаан, англи хэл, математикийн 276 багшийг чадавхжуулах сургалтыг үндэсний зөвлөх багш нартай хамтран зохион байгуулсан ба Баяндун, Дашбалбар, Цагаан-Овоо, Чулуунхороот сумын сургууль болон Хэрлэн сумын 8, Шинэ хөгжил цогцолбор сургуулийн 12 дугаар ангийн 222 сурагчид монгол хэл, англи хэл, хими, биологи, физикийн хичээлээр эрчимжүүлсэн | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | сургалтыг явуулсан. Сургалтын үр дүнд багш нар агуулгыг судлах, технологи, хэрэглээний сорил, даалгавар боловсруулах, туршлагатай багшийн сэдэв, агуулгыг интеграцичлах зэрэг бүтээлч сэтгэлгээний арга зүйд суралцсан. Эрчимжүүлсэн сургалтыг зохион байгуулснаар суралцагчид хүнд болон хоцрогдсон агуулгаа нөхөхөд   дэмжлэг болсон. Үүний үр дүнд аймгаараа элсэлтийн ерөнхий шалгалтад дундаж оноогоо ахиулж, улсын хэмжээнд Дэд байр эзэлж,  англи хэл, нийгэм, монгол хэл, орос хэлний хичээлээр 7 сурагч хэмжээст оноогоор 800-тай үнэлэгдсэн. Нэг сурагч олон улсын англи хэлний шалгалтын оноог ЭЕШ-ын оноотой дүйцүүлэн 800 оноотой шалгагдаж, нийт 8 сурагч аймгийн Засаг даргын захирамжийн дагуу тус бүр 1,0 сая төгрөг, бэлтгэсэн 7 багшид тус бүр 500,000 төгрөг, дундаж оноогоо хамгийн ихээр ахиулсан нэг сургуульд 2,0 сая төгрөг,  дундаж оноогоо ахиулсан 2 судлагдахууны бүлгийн мэргэжлийн бүлгийн хөгжил, сургалт, үйл ажиллагааг дэмжиж тус бүр 1,0 сая төгрөгийн урамшуулал олгосон. | |
| 37 | | 4. Багшийн чадамжид суурилсан хувь | 2022 | Хэрэгжилтийн хувиар | 100 | | “Ментор багш” төслийн хүрээнд 3 удаагийн 14 цагийн “Хувь хүний хөгжил-Багшийн хөгжил- | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | хүний хөгжил, ёс зүй, нийгмийн манлайлал, техник технологийн ур чадварыг дээшлүүлэх "Ментор багш" төсөл хэрэгжүүлнэ | | | | | Байгууллагын хөгжил-Нийгмийн хөгжил" сургалтад 100 багшийг хамруулан зохион байгуулсан. Сургалтад хамрагдсан багш нар судалгаа хийж, 5 контент бүтээж, сайн дурын болон шинэ санаа, санаачилга шингээсэн 3 бүтээлч үйл ажиллагаа зохион байгуулж, 300 гаруй иргэнийг хамруулан нөлөөллийн ажлыг хийсэн. 100 сургагч багш бэлтгэгдэн, судалгаа хийх, илтгэх, манлайлах ур чадвараа дээшлүүлсэн. | |
| 38 | | 5. "Англи хэлтэй Дорнодчууд" хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. | 2022 | Хэрэгжилтийн хувиар | 100 | | "Англи хэлтэй Дорнодчууд" хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр 2022 онд 10,0 сая төгрөг батлуулан хэрэгжилтийг хангасан. Төрийн албан хаагчдын англи хэлний сургалтад 13 агентлагийн 60 албан хаагч, "Англи хэлний цахим уншлагын уралдаан"-д 26 сургуулийн 1339 сурагч англи хэл дээр ном унших дадалд суралцан, уншин чадвараа, англи хэлний ярианы клубийн сургалтад аймгийн 18 сургуулийн 10-11 дүгээр ангийн 120 сурагч оролцон ярианы чадвараа, "Үг цээжилье" уралдаанд аймгийн 23 сургуулийн 2740 сурагч оролцон англи хэлний үгийн нөөцөө нэмэгдүүлэн, "Англи хэлтэй Дорнодын хүүхдүүд" уралдаанд 26 сургуулийн 1-12 дугаар ангийн 289 сурагч оролцон англи хэлний сонсох, ярих, өөрийгөө илэрхийлэх | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | чадвараа нэмэгдүүлсэн. Орон нутгийн мэдээллийн хөтөлбөрийг англи хэл дээр бэлтгэн олон нийтэд хүргэх зорилгоор “Жаран” телевизтэй хамтран “Dornod news in english” 20 удаагийн мэдээллийг хөтөлбөрийг давхардсан тоогоор 39 багш олон нийтэд хүргэн англи хэлний мэдлэг, ур чадвараа дээшлүүлсэн ба аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газар, Жаран ТВ, цахим хуудсаар олон нийтэд хүргэсэн. | |
| 39 | | 6. "Монгол бичгээ суръя" төслийг хэрэгжүүлнэ. | 2022 | Төсөлд хамрагдагсдын хувиар | 100 | | “Монгол бичгээ суръя” төслийн хүрээнд 8 үйл ажиллагаа (телевизийн хичээл, тэргүүний уншигч байгууллага, тэргүүний уншигч сурагч, үндэсний өв 2 гэр бүлийн нэвтрүүлэг, цахим бичвэрийн уралдаан, “Үндэсний бичиг бидний бахархал”, үндэсний бичгийн кабинет тохижуулахад дэмжлэг үзүүлэх), 5 сургалтыг зохион байгуулж, 2248 сурагч, иргэд, албан хаагчдыг хамруулсан. Хэлний бодлогын үндэсний зөвлөл, Дорнод аймгийн Хэлний бодлогын салбар зөвлөл хамтран зохион байгуулсан сургалтад Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв болон 12 сургууль, 4 цэцэрлэгийн 30 багш, аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч 12 агентлагийн 18, 9 сумын 16, нийт 64 төрийн албан хаагч хамрагдан монгол хэлний зөв | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | бичиг, үндэсний бичиг, уран бичгийн мэдлэг, чадвараа ахиулсан. Үндэсний бичгийн “Теле хичээл” 20 дугаарыг телевизээр иргэдэд хүргэж, цахим хуудсаар давхар нийтлэгдсэн дугаар бүр 1000-5000 хүний хандалттай байна. “Тэргүүний уншигч” шалгаруулах уралдаанд 25 сургуулийн 114 сурагч, 23 албан байгууллагын 240 албан хаагч, 14 сумын Засаг даргын тамгын газар болон байгууллагын 305 албан хаагч, 34 сургуулийн өмнөх боловсролын байгууллагын 435 албан хаагч хамрагдан нийт 980 албан хаагч, хамрагдаж үндэсний бичгээр унших чадвараа ахиулсан. “Үндэсний өв 2” телевизийн нэвтрүүлэгт 11 гэр бүл, бичгийн цахим бичвэрийн уралдаанд 3 сум, 6 агентлаг, 11 сургуулийн 31 төрийн албан хаагч, “Үндэсний бичиг бидний бахархал” монгол бичгийн уралдаанд 150 гаруй иргэд оролцсон ба сургалтад хамрагдан үндэсний бичгээрээ бичих, унших чадвараа ахиулсан. Хэрлэн сумын 1 дүгээр сургуульд 1,0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлж, “Амин бичиг” үндэсний бичгийн танхим тохижуулснаар сурагчдад сурах таатай орчин, сургалтын хэрэглэгдэхүүнээр хангагдсан. Төслийн үр шимийг аймгийн иргэд, | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | төрийн албан хаагч, багш сурагчдад тэгш хүртээмжтэй хүртэж байна. | |
| 40 | | 7. Багийн бага сургууль байгуулна /Матад сум/ | 2022 | Байгуулагдсан эсэх | 1 | | Багийн бага сургуулийн барилга (Матад сум) барих ажил 2022 оны төсөвт тусган батлагдсан боловч аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 10/2 дугаар тогтоолоор хасагдсан. | 0% |
| 41 | | 8. Ерөнхий боловсролын сургуулийн 1 дүгээр ангийн сурагчдад зориулж "Эрүүл мэндийн дэвтэр" төсөл хэрэгжүүлнэ. | 2022 | Төсөлд хамрагдсан сургуулийн эзлэх хувь | 100 | | Сургуулийн насны хүүхдийн бие бялдрын хөгжил, дархлаажуулалт, эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээний тусламжтай сурагч нэг бүрийн эрүүл мэндэд тавих хяналтыг сайжруулах, “Эрүүл мэндийн дэвтэр” төслийг хэрэгжүүлэхээр нийт 10.0 сая төгрөг батлагдсан. Аймгийн Засаг даргын 2022 оны А/250 дугаар захирамжаар Эрүүл мэндийн дэвтэр хүлээн авах комисс нь захиалагч, гүйцэтгэгчийн хооронд байгуулсан ОНТ-2.5.36/2022 тоот гэрээний дагуу ерөнхий боловсролын сургуулийн нэгдүгээр ангийн сурагчдад зориулж, “Эрүүл мэндийн дэвтэр”-ийг хүлээн авч, 1 дүгээр ангийн 2101 хүүхдэд хүлээлгэн өгч, сургалтад ашиглан ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн сургалтын менежер 26, 17 эмчийг хамруулан зөвлөмж, чиглэл өгч, хүүхдийн эрүүл мэндийн тэмдэглэлийг хөтөлж байна. | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 42 | | 9. "Цахим анги" төсөл хэрэгжүүлнэ. | 2022 | Танхимын тоо | 1 | | Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтээр “Цахим анги” төсөл арга хэмжээг хэрэгжүүлэн 100 сая төгрөгийн цахим ангийн тоног төхөөрөмжийг 6 сургуульд нийлүүлсэн нь ээлжит хичээлийн цахим контент бэлтгэх ажилд идэвхтэй оролцуулахад бодит дэмжлэг болж байна. Мэдлээ.мн цахим санд ерөнхий боловсролын 11 сургуулийн 10 судлагдахууны мэргэжлийн багш нар 173 ээлжит хичээл байршуулсан. Боловсрол, шинжлэх ухааны сайд эхний ээлжинд хичээл байршуулсан 43 багшид “Талархал” гардуулсны 10 нь Дорнод аймгийн багш байсан бөгөөд хамгийн олон хичээл байршуулсан аймгаар шалгарсан. | 100% |
| 43 | | 10. Сургууль, цэцэрлэгийг “Багш хөгжлийн төв”-тэй болгох ажлыг үргэлжлүүлнэ. | 2022 | Төвийн тоо | 66 | | Дорнод аймгийн төрийн болон төрийн бус өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгт “Багш хөгжлийн төв”-ийг 2016 оноос шат дараатай байгуулж байгаа бөгөөд 2022 онд шинээр 2 сургууль, 2 цэцэрлэгт багш хөгжлийн төв нийлүүлснээр аймгийн хэмжээнд 66 төвтэй болж, 26 сургуулийн 884 багш, 31 цэцэрлэгийн 259 багш тохилог таатай орчинд ажиллаж, хөдөлмөрлөж байна. Политехникийн коллежоос багш нарын сургалтын арга зүй, чанар, судалгаа шинжилгээ, ажлын байран дээр тасралтгүй хөгжих боломжийг | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | бүрдүүлсэн цахим сургалтын орчныг иж бүрэн тохижуулах сургалтын контентуудыг тогтвортой бэлтгэн, түгээх зорилгоор “Багш хөгжлийн төв, контент хөгжүүлэлтийн танхим”-ыг байгуулах төслийг Германы хамтын ажиллагааны нийгэмлэг (GIZ) төсөлд хүргүүлэн 75,0 сая төгрөг батлуулаад байна. | |
| 44 | | 11. "Хүн болох багаасаа" төсөл болон "Ирээдүйгээ амьдралд бэлтгэе" төсөл хэрэгжүүлнэ. | 2022 | Хамрагдалтын хувь | 100 | | “Хүн болох багаасаа” хөтөлбөрийг хэрэгжүүлэх 4 зорилт, 12 арга хэмжээг 26 сургууль, 36 цэцэрлэг 100% хэрэгжүүлсэн. Цагаан зээрийн үнэ цэнэ, ач холбогдлыг сурталчлан таниулах, цагаан зээрийг хайрлан хамгаалахад хүүхдийн оролцоог нэмэгдүүлж, дуу хоолойг нь олон нийтэд хүргэх, тэднийг багаас нь байгалиа хайрлан хамгаалах, байгальтай зүй зохистой харьцах, дадал заншил, идэвх санаачилгыг төлөвшүүлэх зорилготой “Янзаган хүрээг хайрлаарай” аянд аймгийн ерөнхий боловсролын 8 сургуулийн 8 багш, эко клубийн 24 сурагч оролцон, цагаан зээр хамгаалах чиглэлээр өөрийн орон нутагтаа хийж хэрэгжүүлсэн ажлаа танилцуулан, тулгамдаж буй асуудал, цаашид авах арга хэмжээний талаар хэлэлцэн, нэгдсэн уриалга гаргаж санал бодлоо илэрхийллээ. “Хийн түлш-Бидний ирээдүй” сэдэвт | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | сургалтад ерөнхий боловсролын 12 сургуулийн 8-12 дугаар ангийн 366, эсээ бичлэгийн уралдаанд 35 суралцагч, “Дагуурын” дархан газрын эко бүс нутгууд болон байгалийн орчны талаарх мэдлэгийг нэмэгдүүлэх, байгалиа хайрлан хамгаалах үзлийг төлөвшүүлэх, уран зургийн төсөөлөх болон бүтээлч чадварыг хөгжүүлэх зорилгоор гар зургийн уралдаанд 5-18 насны 20 хүүхэд хамрагдсан. Бага ангийн 4162, цэцэрлэгийн 6500 хүүхэд түүхэн дуу, бага ангийн 3536, цэцэрлэгийн 5800 хүүхэд шүлэг, яруу найраг, бага ангийн 506, цэцэрлэгийн 2456 хүүхэд бүжиг сурч, бага ангийн 1968 хүүхэд домог ярьж чаддаг болсон. | |
| 45 | 2.4.1. Соёл урлагийн салбарын хөгжлийг дэмжиж, үндэсний бахархал, уламжлалт өв соёлоо дээдэлж, иргэдийг соён гэгээрүүлэх, соёлын бүтээлч үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ. | 1. “Соёл урлагийн салбарын хөгжлийг дэмжих” арга хэмжээ хэрэгжүүлнэ. | 2022 | Хамрагдагсдын хувиар | 100 | | Аймгийн Засаг даргын А/119 дүгээр захирамжаар “Аймгийн соёл, урлагийн салбарын хөгжлийг дэмжих” арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор 4 зорилтын хүрээнд 17 үйл ажиллагаа төлөвлөж, 100 сая төгрөгийн төсөв батлуулж, 10 үйл ажиллагаа бүрэн дуусаж, 62,9 сая төгрөг зарцуулагдсан, 7 үйл ажиллагаа явцын шатандаа үргэлжилж байна. Зорилт 1-ийн хүрээнд Соёлын ажилтны уулзалт, зөвлөгөөнийг зохион байгуулж, бүх сумын мэргэжлийн ажилтнууд оролцсон, хүүхдийн авьяас чадварыг хөгжүүлэх дугуйлан | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | секцүүд хичээллэж, 290 гаруй хүүхдүүдийг хамруулсан. Зорилт 2-ын хүрээнд “Үл бүдгэрэх их өв” 2022 төсөл амжилттай хэрэгжиж, СББӨ-ийн 5 төрлөөр сургалт, хэлэлцүүлэг, уралдааныг Соёлын яам, аймгийн Засаг даргын тамгын газар, Шинжлэх ухааны Академийн Хэл зохиолын хүрээлэнтэй хамтран зохион байгуулж, 330 гаруй ардын авьяастан, анхлан суралцагч, хүүхэд багачууд, багш сурган хүмүүжүүлэгч нарыг оролцуулсан. Зорилт 3-ын хүрээнд Соёл урлагийн байгууллага, уран бүтээлчид, ардын авьяастнуудыг олон улс, улс, бүсийн чанартай уралдаан тэмцээнд оролцоход зориулж 8,0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Зорилт 4-ийн хүрээнд Үндэсний бичиг үсгийн баяр, Үндэсний номын баярын өдрүүдийг аймгийн хэмжээнд тэмдэглэн өнгөрүүлж, 3200 гаруй иргэд олон, нийт оролцсон. | |
| 46 | | 2. “Талын соёл” зорилтот төсөл, "Алтаргана", "Баргажин", "Алтан дөрөө", "Хатагин" үндэсний өв соёлын эвент арга хэмжээ хэрэгжүүлнэ. | 2022 | Зохион байгуулсан ажлын хувиар | 100 | | “Талын соёл” зорилтот төсөл эвент арга хэмжээний хүрээнд Ардын хувьсгалын 100, 101 жилийн ой, Дорнод аймаг байгуулагдсаны 90, 91 жилийн ойн баяр наадмыг 07 дугаар сарын 07-11-ний өдрүүдэд зохион байгуулсан. Мөн уламжлал болгон зохион байгуулагддаг буриад, барга, үзэмчин, халх угсаатны “Алтаргана”, “Баргажин”, | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | “Алтан дөрөө”, “Хатагин” наадмуудыг 07 дугаар сарын 22-оос 08 дугаар сарын 07-ны өдрийн хооронд зохион байгуулж, урлаг, спортын шилдгүүдийг тодруулсан. Дээрх арга хэмжээнүүдэд нийт давхардсан тоогоор 43,7 мянган хүүхэд, залуус, ахмад буурлууд хамрагдсан. Угсаатны наадмуудаас Буриад түмний “Алтаргана” наадам ОХУ-ын Өвөрбайгалийн хязгаарын Агын буриадын тойрогт зохион байгуулагдсанаараа онцлог бөгөөд тус наадамд манай аймгийн баг хамт олон ОХУ, Монгол Улс, БНХАУ, Кыргызстан, Казакстан зэрэг улсуудад тархан суурьшсан буриад зон олонтой 11 төрөлд өрсөлдөж, 1 гран при, 6 алт, 2 мөнгө, 1 хүрэл, 1 тусгай байрын шагнал хүртсэн амжилт үзүүлсэн. | |
| 47 | | 3. Хүүхдийн "Хөгжмийн боловсрол" төсөл хэрэгжүүлнэ. | 2022 | Төсөл хэрэгжсэн эсэх | 100 | | “Хөгжмийн боловсрол” төслийн хүрээнд 5 зорилт, арга хэмжээг төлөвлөн 100 хувь хэрэгжүүлсэн. “Хүүхдэд хөгжмийн боловсрол олгох төсөл”-ийн хүрээнд 5 сургуулийн 8 багш, Хөгжимт драмын театрын 2 багш, нийт 10 багш морин хуур, ёочин, хуучир, лимбэ, бишгүүр, үлээвэр хөгжмийн дугуйланд 5 сургуулийн 100 сурагчийг хамруулан сургаж байна. Сурагчид дугуйлангаар тус бүр 2 актав гамм, 2-3 дасгал, насны онцлогт тохирсон 2-3 зохиол тоглож | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | сурсан. Төслийн санхүүжилтээр 3 хуучир, 2 шанз хөгжим болон хийлийн утсыг 4 сургуульд нийлүүлэн хөгжмийн зэмсгийн хангалтад дэмжлэг болсон. | |
| 48 | | 4. "Хүүхдийн цаг" төсөл хэрэгжүүлнэ. | 2022 | Хэрэгжилтийн хувиар | 100 | | Хүүхдийн хөгжил, авьяас, ур чадвар, техник сэтгэлгээ, төлөвшлийг дэмжих "Хүүхдийн цаг хөтлөгч" төслийн хүрээнд 7 зорилт арга хэмжээг төлөвлөн 100 хувь хэрэгжүүлэн "Бид Дорнодын хүүхдүүд", "Би монгол хүн", "Тал нутгаар аялахуй", "Мэргэжил бүхэн сайхан" нэвтрүүлгүүд болон "Бид хүүхдүүд", "Болзошгүй эрсдэлээс хүүхэд өөрийгөө хамгаалж сурах вэ?" богино хэмжээний шторк, "Ахмадын сургаал алт" нэвтрүүлгийг бэлтгэн "Шинэ суваг" телевизээр сурталчлан, олон нийтэд хүргэсэн. | 100% |
| 49 | | 5. "То ван"-ийн өв соёлын өргөө /Халхгол сум/ байгуулна. | 2022 | Байгуулсан эсэх | 1 | | Аймгийн төсвийн тодотголоор 2022 оны төсвөөс хасагдаж, дахин санал хүргүүлж, 2023 оны Халхгол сумын орон нутгийн төсөвт өртөг нэмэгдэж 230,0 сая төгрөгөөр суугдсан. | 0% |
| 50 | | 6. "Нэг голын хүүхдүүд" төсөл хэрэгжүүлнэ. | 2022 | Төсөлд хамрагдсан сургуулийн эзлэх хувь | 100 | | Хэрлэн голын сав газрын захиргаатай хамтран "Дэлхийн усны өдөр"-ийг тохиолдуулан "Газрын доорх усыг илүү танин мэдэхүй" сэдвийн хүрээнд цэцэрлэгийн болон ерөнхий боловсролын сургуулийн хүүхдүүдэд газрын | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | доорх усны бүтэц, нөөцийн хомсдол, бохирдлоос хамгаалах шалтгааныг ойлгуулах, сургалтын хэрэглэгдэхүүн бэлтгэх зорилгоор макетны уралдааныг сургууль, цэцэрлэгийн багш нарын дунд зарлаж дүгнэсэн. Хэрлэн голын сав газрын захиргаанаас бэлтгэсэн байгаль орчны чиглэлээр 25 сэдвийн хүрээнд цахим хичээл, шторк бэлтгэж хүргүүлсэн. Хэрлэн сумын 2 дугаар цэцэрлэгт “Усны бүлэг” танхимыг тохижуулж, сургалтын хэрэглэгдэхүүнийг хүлээлгэн өгсөн. Танхимыг тохижуулснаар аймгийн хэмжээнд жишиг болохуйц сургалтын орчныг бүрдүүлж, хүүхэд багаасаа усны үнэ цэнэ, ач холбогдлын талаар ойлголттой болох боломж бүрдсэн. Мөн сурагчдын хийн түлшний талаарх мэдлэг, ойлголтыг дээшлүүлэх, утааны эсрэг байгальд ээлтэй шийдлийг эрэлхийлэх, байгаль орчноо хамгаалах үйлсэд чиглүүлэх, ус болон хийн түлшний харилцан хамаарлыг мэдүүлэх зорилгоор Буйр нуур, мэнэнгийн талын сав газрын захиргаа, “Дашваанжил” ХХК-тай хамтран “Хийн түлш-Бидний ирээдүй” сэдэвт эсээ бичлэгийн уралдааныг ерөнхий боловсролын сургуулийн 8-12 дугаар ангийн суралцагчид зарлаж, дүгнэсэн. Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Дорнод хамгаалалтын захиргаанаас хүүхэд, залуучууд болон хойч үеийнхэндээ байгаль орчноо хайрлан хамгаалах талаар ойлголт өгөх, гурван улсын хамтарсан “Дагуурын” дархан газрын эко бүс нутгуудын талаарх мэдээллийг олгох, хүүхэд залуучуудын байгалийн орчны талаарх мэдлэгийг нэмэгдүүлэх, уран зургийн төсөөлөх болон бүтээлч чадварыг хөгжүүлэх зорилгоор 5-18 насны хүүхэд, сурагчдын дунд гар зургийн уралдааныг зарлаж дүгнэсэн. | |
| 51 | | 7. “Түүхт нутгаар аялахуй” виртуал музей төсөл хэрэгжүүлнэ. | 2022 | Хэрэгжилтийн хувиар | 100 | | Орон нутгийн төсвийн 54,8 сая төгрөгийн санхүүжилтээр Дорнод аймгийн Музейн үзмэрийн төрөл зүйлийг нэмэгдүүлэх, хадгалалт хамгаалалтыг сайжруулах зорилгоор “Түүхт нутгаар аялахуй” виртуал музей төслийн сонгон шалгаруулалтыг зарлаж, тендерт “Гэрэгэ дижитал” ХХК шалгаран гэрээ байгуулж, дуусах шатанд явагдаж байна. | 30% |
| 52 | 2.5.1. Хөдөлмөрийн зах зээлийн судалгаа, бүс, орон нутгийн хэрэгцээнд тулгуурлан аймгийн | 1. “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар зөвлөл"-ийн үйл ажиллагааны зардал | 2022 | Хэрэгжилт хувиар | 100 | | Аймгийн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлийн үйл ажиллагааны 2022 оны төлөвлөгөөг батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Төлөвлөгөөний хүрээнд Мэргэжлийн боловсролын байгууллагад Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн жишиг | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | хөдөлмөр эрхлэлтийн бодлогыг хэрэгжүүлэх замаар ажилгүйдлийн түвшинг бууруулах зорилтот ажлуудыг зохион байгуулна. | | | | | | танхим тохижуулах, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үндэсний зөвлөлөөс зарласан Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сарын аянаар сургалт, мэдээллийн хэрэгслээр нийгэмд хандсан нөлөөллийн ажлыг зохион байгуулах зэрэг 6 ажил үйлчилгээгээр дамжуулан 7 удаагийн арга хэмжээг зохион байгуулж, 320 иргэнийг хамруулан 29,0 сая төгрөгийг зарцуулсан. | |
| 53 | | 2. “Нэг өрх-Нэг ажлын байр” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. | 2022 | Хөтөлбөрийн хэрэгжилт хувиар | 100 | | Хөтөлбөрийн хүрээнд сумдын Амьжиргааг дэмжих зөвлөлтэй хамтран нийгмийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрх, иргэний судалгааг гарган, мэдээллийн сан үүсгэж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээнд 256 иргэнийг хамруулсан. Түр ажлын байранд 180 иргэн, байнгын ажлын байранд 86 иргэн, өөрөө өөртөө ажлын байр бий болгох санаачилгыг дэмжих ажлын хүрээнд Булган, Цагаан-Овоо, Матад сумдад тус бүр 2,0 сая төгрөгийн тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлээд байна. | 100% |
| 54 | | 3. Start-up төвөөр дамжуулан залуучуудын хөдөлмөр | 2022 | Төсөл хэрэгжүүлсэн багийн тоо | 2 | | “Орон нутгийн санхүүжилтээр залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих старт ап төвийн байнгын үйл ажиллагааг дэмжих зорилгоор орон нутгийн төсөвт 35,0 сая төгрөг | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | эрхлэлтийг нэмэгдүүлнэ. | | | | | батлагдсан. Үүний үр дүнд тус төвийн үйл ажиллагааг хариуцан ажилладаг 2 залуучуудыг байнгын ажлын байраар хангаж, 10 ментор шинээр бизнесээ эхлүүлэхээр төлөвлөж байгаа залуучуудад 28 удаагийн эвэнт арга хэмжээ зохион байгуулж, 35 шилдэг бизнес санааг хөгжүүлэх сургалтад хамруулж, хөдөлмөр эрхлэх ур чадвар олгоод байна. Мөн Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн Start-up арга арга хэмжээнд аймгийн хэмжээнд 8 баг өрсөлдөж, 3 баг нь хурдасгуур хөтөлбөрт хамрагдан олон нийтэд бэлтгэсэн төслөө танилцуулан “Молйхон” оёмол хүүхдийн тоглоомын үйлдвэрлэх баг шалгарч 10 сая төгрөгийн буцалтгүй дэмжлэгт хамрагдаж, 2 иргэн байнгын ажлын байраар хангагдсан. | |
| 55 | | 4. Хүмүүнлэгийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, төр-улаан загалмайн хамтын ажиллагааг бэхжүүлэх Хүмүүнлэгийн дэд хөтөлбөр хэрэгжүүлнэ. | | Хөтөлбөрт хамрагдсан иргэдийн тоо | 21000 | | Аймгийн Засаг даргын 2022 оны А/88 дугаар захирамжаар “Хүмүүнлэгийн дэд хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх 5 зорилтын хүрээнд 11 төрлийн үйл ажиллагааг зохион байгуулах 10,0 сая төгрөгийн зардлыг баталж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Төлөвлөгөөний дагуу эрүүл мэндийн чиглэлээр Коронавируст халдвар (Covid-19) цар тахлаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулахад дэмжлэг үзүүлэх 66 | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | сайн дурын ажилтан ажиллаж, 4500 хүнд үйлчилгээ үзүүлсэн. Улсын хэмжээнд зохион байгуулагдсан Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн сарын аяны хүрээнд 12 байгууллагад анхны тусламжийн сургалтыг 800 хүнд зохион байгуулсан. Хүүхэд залуучуудын хөтөлбөрөөр 3200 хүүхэд, багачуудад хүмүүнлэгийн үйлсийн талаарх сургалт, нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулсан. | |
| 56 | | 5. Аймгийн хөдөлмөрийн насны хүн амын нийгмийн даатгалд хамрагдалтыг нэмэгдүүлнэ. | 2022 | нийгмийн даатгалд хамрагдсан хүний тоо | 25000 | | 2022 онд нийт 617 аж ахуйн нэгж, байгууллагын 17661 албан журмын даатгуулагч нийгмийн даатгалын шимтгэл төлж 28,7 тэрбум төгрөгийг нийгмийн даатгалын санд хуримтлуулсан. Тайлант онд шинээр 72 байгууллагын 205 албан журмын даатгуулагч шимтгэл төлөгчөөр бүртгүүлж, сайн дурын даатгалд 4938 даатгуулагч хамрагдаж, нийт 22599 иргэнийг нийгмийн даатгалд хамруулсан үзүүлэлттэй байна. Дээрх үзүүлэлтийг өнгөрсөн оны мөн үеийн суурь түвшинтэй харьцуулахад 96,11 хувийн гүйцэтгэлтэй байна. Хамрагдалт буурсан шалтгаан нь эдийн засгийн нөхцөл байдлаас шалтгаалж, ажилгүйдлийн тэтгэмж авагчдын тоо өсч, даатгуулагчийн тоо буурсан. | 70% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 57 | 2.5.2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд чиглэсэн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ. | 1. “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжил хамгаалал” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. | 2022 | Хөтөлбөрт хамрагдалтын хувиар | 100 | | Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний дагуу 4 зорилтын хүрээнд 45 ажил арга хэмжээг төлөвлөснөөс 3 арга хэмжээ тасарч, 42 ажил арга хэмжээ зохион байгуулагдаж давхардсан тоогоор 2500 орчим иргэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эх, асран хамгаалагч нар хамрагдсан. “Хөгжлийн бэрхшээл ба тэгш байдал” сургалтыг Хэрлэн сумын сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсролын сургуулийн арга зүйч, нийгмийн ажилтан, банкны ажилтнууд, төрийн байгууллагын 748 албан хаагчдад, Хэрлэн сумын 8 дугаар сургуулийн 280 гаруй сурагч нийт 1028 иргэнийг хамруулсан. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, иргэд, тэдний асран хамгаалагч, төрийн бус байгууллагын дунд спортын арга хэмжээ зохион байгуулахаас гадна улс, бүсийн  спортын уралдаан тэмцээн спарткадад оролцоход дэмжлэг үзүүлж, Монголын тусгай олимпын хороотой хамтран Зүүн бүсийн тусгай олимп, сургалт, эрүүл мэндийн үзлэгийг, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн зүүн бүсийн аварга шалгаруулах олон төрөлт тэмцээнийг аймагтаа зохион байгуулсан. Сургалтын үр дүнд иргэд хүүхдийн харилцаа, хандлага өөрчлөгдсөн ба аж ахуйн нэгж, | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | байгууллагуудын үйлчилгээ сайжирч,ээрэг өөрчлөлтүүд гарч эхэлсэн. Өнгөрсөн 2021 оны үйл ажиллагаатай харьцуулахад хөтөлбөрийн санхүүжилт нэмэгдсэн нь хамрагдсан иргэдийн тоо, зохион байгуулсан ажлын тоо, чанар нэмэгдсэн. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг асарч байгаа асран хамгаалагч нарын хэрэгцээ шаардлагыг үндэслэн үйлчилгээг ойртуулж сумдад түлхүү ажиллаж эхэлсэн. | |
| 58 | 2.5.3. Ахмадуудын идэвх, санаачилгатай ажлуудыг дэмжиж, ажил, амьдралын туршлагыг нь залуу үед өвлүүлнэ. | 1. “Ахмадын ачлал” хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ. | 2022 | Хөтөлбөрийн хэрэгжилт хувиар | 100 | | Хөтөлбөрийн 3 зорилтын хүрээнд тусгагдсан ажлуудыг аймгийн Засаг даргын тамгын газар, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, аймаг, сумын ахмадын хороо, зөвлөлүүдтэй хамтран зохион байгуулсан. Нийт 17 арга хэмжээ зохион байгуулахаас 13 үйл ажиллагааг зохион байгуулж, 1200 орчим ахмад настныг хамруулсан. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, аймаг, сумын Ахмадын хороо, зөвлөлүүдтэй хамтран “Ахмад залуу үеийн спорт уулзалт”, аймгийн аварга шалгаруулах “Гар бөмбөг”-ийн тэмцээн, “Шагайн харваа”, “Тэрбум мод”, “Мэндийн ерөөлтэй миний Дорнод”, “Мартагдсан аялгуу”, “Ахмадын сургаал алт”, “Нөхөрсөг уулзалт”, “Эргэн дурсахуй”, “Ахмад настан ба цахим хэрэглээ” зэрэг | 70% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | ахмадын байгууллага болон ахмадуудад чиглэсэн сургалт, мэдээллийн арга хэмжээг төрийн болон бусад 7 аж ахуйн нэгж, байгууллагатай хамтран 615 ахмад настанд цахим орчны хэрэглээ ба тоног төхөөрөмж, E-mongolia, E-Halamj системийн ашиглалт хэрэглээний тухай мэдлэг ойлголт өгсөн. Ахмад мэргэжилтнүүдийн ажлын туршлага, мэдлэг чадварыг үнэлж, бусдад зөвлөх, туслах боломжийг бүрдүүлсэн. | |
| 59 | | 2. Аймаг, сум, багийн Ахмадын хороо, зөвлөлийн үйл ажиллагаанд дэмжлэг урамшуулал олгоно | 2022 | Дэмжлэг, урамшуулалд хамрагдсан ахмадын байгууллагын тоо | 25 | | Аймгийн 14 сумын ахмадын хороо, Хэрлэн сумын 11 ахмадын зөвлөлийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, харилцаа холбоо, унаа шатахууны дэмжлэг үзүүлж, урамшуулалд зориулж, 2022 онд нийт 63,0 сая төгрөгийг олгоод байна. Ингэснээр Ахмадын хороо, зөвлөлүүдийн ажил тогтворжиж, ахмадуудад чиглэгдсэн ажлын үр дүн сайжирч, ахмад настанд хүргэх хөгжлийн үйлчилгээ нэмэгдээд байна. | 100% |
| 60 | | 3. Аймгийн 90 ба түүнээс дээш настай ахмадуудад хүндэтгэл үзүүлнэ. | 2022 | Ахмадын тоогоор | 70 | | Ахмад настны тухай хуулийн дагуу жил бүр уламжлал болгон зохион байгуулж ирсэн Билгийн тооллын Арван долоо дугаар жарны “Буян үйлдэгч” хэмээх усан Бар жилийн Сар шинийн баяраар аймгийн 90-ээс дээш настай нийт 65 ахмадуудад хүндэтгэл үзүүлж, | 90% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | аймгийн Засаг даргын мэндчилгээ, гарын бэлгийг хүргүүлж, хүндэтгэл үзүүлсэн. | |
| 61 | 2.6.1. “Гэр бүл төвтэй хүний хөгжил”-ийг дэмжиж, хүүхдэд ээлтэй аймаг болох зорилтыг хэрэгжүүлж, орон нутгийн хөгжилд оюутан, залуусын оролцоог нэмэгдүүлнэ. | 1. “Хүүхдэд ээлтэй орон нутаг” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. | 2022 | Хөтөлбөрийн хэрэгжилт хувиар | 95 | | “Хүүхэд хамгааллын явуулын үйлчилгээ”, Нийгмийн цогц явуулын үйлчилгээ”, “Хүчирхийлэлгүй хүүхэд 30 хоног”, “Анхаарч хамгаалъя” аян, “Хүүхэд эрхэм хэрэглэгч” аяны хүрээнд 1150 багш, ажилчдад хүүхэд хамгааллын бодлого, 3653 эцэг эхэд хүүхэд хүмүүжлийн зэрэг арга, эцэг эхийн үүрэг хариуцлага, 4786 хүүхдэд хорт зуршил, гэмт хэргийн талаарх сургалт, мэдээллийг өгч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлсэн. Хүүхдийн эрх зөрчигдсөн 134 утасны дуудлага, 71 өргөдөл, гомдол бичгээр хүлээн авч, 208 хүүхдэд шуурхай тусламж, хамгааллын хариу үйлчилгээ үзүүлж, 110 хүүхдийн мөнгөн тэтгэмжийн зөрчлийг шийдвэрлэж, нийт 318 (эр 135, эм 183) хүүхдийн зөрчигдсөн эрхийг шийдвэрлэсэн нь өмнө онтой харьцуулахад дуудлага, мэдээлэл 32 тохиолдлоор буурч, шийдвэрлэлт 92,9% байна. Хүүхдийн эрхийн стандартын хэрэгжилтийг хангах чиглэлээр хүүхдийн зуслан, хүүхэд асрах хувилбарт үйлчилгээ, хүүхэд харах үйлчилгээ, хүүхдийн тоглоомын талбайд тус тус хяналт шалгалтыг хийж зөвлөмж 3, албан шаардлага | 90% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 1-ийг холбогдох газруудад өгч зөрчлийг арилгуулсан. | |
| 62 | | 2. "Хүүхэд эрдэнэ" арга хэмжээ хэрэгжүүлнэ. | 2022 | Хэрэгжилт хувиар | 95 | | "Хүүхэд эрдэнэ" арга хэмжээг 2022 оны 8 дугаар сард Халхгол суманд зохион байгуулахаар төлөвлөж, бэлтгэл ажлыг хангаад байсан боловч, тус суманд малын гоц халдварт өвчний дэгдэлт эрс нэмэгдэж, хорио цээрийн дэглэмд шилжсэн учраас олныг хамруулан зохион байгуулаагүй. Аймгийн төв Данригданжаалин хийдээс цөөн тооны лам нар очиж, тахилгын үйлийг хийсэн. | 50% |
| 63 | | 3. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үйл ажиллагааг орон нутагт хэрэгжүүлнэ. | 2022 | Хэрэгжилт хувиар | 95 | | Үйл ажиллагааны хүрээнд 6 төрлийн ажил, үйлчилгээ зохион байгуулахаар төлөвлөснөөс "Харилцан хүндэтгэе" аян", "Жендерийн 16 хоногийн аян", "Жендерийн эрх тэгш байдлыг хангах сургалт" нөлөөллийн ажлыг зохион байгуулсан. Мөн 4 төрлийн нөлөөллийн зурагт хуудсыг 12 удаа цахим хуудсаар дамжуулан 8000 хүнд хүргэсэн. Орон нутгийн цахим хуудас, ТВ-6 телевиз, багийн гишүүд өөрсдийн цахим ном болон хариуцан ажилладаг мэдээллийн сайт, хуудас, бүлгүүдтэй хуваалцан иргэдэд жендерийн талаарх мэдээллийг 13635 иргэнд түгээсэн. | 90% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 64 | | 4. “Эмэгтэйчүүдийн хөгжлийн хөтөлбөр”-ийг хэрэгжүүлнэ. | 2022 | Хөтөлбөрт хамрагдалтын хувиар | 20 | | Хөтөлбөрийг “Зорилготой амьдрал” төрийн бус байгууллагаар гэрээ байгуулан гүйцэтгүүлж байна. Хөтөлбөрийн хүрээнд аймгийн Эрүүл мэндийн газар, “Хатан сэлбэ” ТББ, Иргэний нийгмийн зөвлөл, “Ухаарал” эмнэлэгтэй хамтарч “Архинд донтох, түүнээс урьдчилан сэргийлэх нь” сургалтыг 450 хүнд хүргэж, 20 хүнийг эмчилгээнд хамруулж, 8 ам бүлтэй айлын байрыг засуулсан. Мөн архины шалтгаант сэтгэц, зан үйлийн эмгэгтэй болсон 20 хүн (6 нь эмэгтэй)-ийг эрүүл мэндийн үзлэгт оруулж, архины донг эмчлэх эмчилгээнд хамруулж байна. Эмэгтэйчүүдийн “Улс төрийн 2020”, “Herbo Life” клубүүдийн 10 гаруй гишүүдтэй уулзалт, ярилцлага зохион байгуулсан. “Охид монголын ирээдүй” илтгэлийн уралдаанд 14 сумын 80 гаруй ахлах ангийн охид оролцсоноос Цагаан-Овоо, Сэргэлэн, Халхгол сумдын суралцагч нарт өргөмжлөл, дурсгалын зүйлс гардуулсан. Орон нутгийн хөгжилд эмэгтэйчүүдийн оролцоо-манлайлал зөвлөгөөнийг “Оролцъё төлөөлье” уриатай зохион байгуулж, 300 эмэгтэйчүүдийг хамруулсан. Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр 10 эмэгтэйд 25,0 сая төгрөгийн дэмжлэгийг орон нутгийн төсвөөс | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | үзүүлж, 120 эмэгтэй сургалтад хамрагдаж, 160 гаруй ажлын байртай болсон нь нийт эмэгтэйчүүдийн 11,1 хувь нь ажил хөдөлмөрт зуучлагдсан. “Аз жаргал” төвөөр өсвөр насны 588 хүүхэд үйлчлүүлсэн нь өмнөх оноос 17,6 хувиар нэмэгдсэн. Төлөвлөгдсөний дагуу нийт 35 төрлийн арга хэмжээнд 13355 (эр 4674 эм 8680) буюу өмнө онтой харьцуулахад 50 хувиар хамрагдалт өссөн. | |
| 65 | | 5. Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхэд иргэдэд нийгмийн хамгаалал, хууль эрх зүйн дэмжлэг үйлчилгээ үзүүлдэг “Нэг цэгийн үйлчилгээний төв”-ийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлнэ. | 2022 | Үйлчилгээ үзүүлсэн иргэдийн тоо | Тохиолдлын тоогоор | | Аймгийн Засаг даргын 2022 оны А/94 дүгээр захирамжаар “Нэг цэгийн үйлчилгээний төв”-ийн урьдчилан сэргийлэх нийгмийн ажлын үйлчилгээ, үйл ажиллагаанд зориулан 11,2 сая төгрөгийн дэмжлэг үзүүлж, үйл ажиллагааг нь зохион байгуулж байна. Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн нийт 48 хүнээс хүүхэд 33 (эр 12, эм 21) насанд хүрэгч 15 эмэгтэйг нэг цэгийн үйлчилгээний төвд 780 хоног байршуулж, хохирогчийн аюулгүй байдлыг хангаж, хууль эрх зүйн болон сэтгэл зүйн, үйлчилгээ үзүүлээд байна. | 100% |
| 66 | | 6. Гамшигт тэсвэртэй орон нутаг төслийн хүрээнд хүүхэд багачуудад гамшгийн эрсдэлийн | 2022 | Байгуулсан эсэх | 1 | | Дэлхийн зөн олон улсын байгууллагын дэмжлэг, аймгийн орон нутгийн төсвийн санхүүжилтээр гамшгийн эрсдэлийн талаар мэдлэг олгох “Аврагч мазаалай” сургалтын танхимыг | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | талаар мэдлэг олгох “Аврагч мазайлай” сургалтын танхим байгуулахад орон нутгаас хариуцах зардал | | | | | 2022 оны 09 дүгээр сард байгуулж, нээлтээ хийсэн. Одоогийн байдлаар тус танхимаар нийт 1217 хүүхэд (эр 535, эм 682) хүүхдүүд гамшгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх, дадлага сургуулилтад хамрагдаад байна. | |
| 67 | 2.7.1 . Аймгийн “Залуучуудын хөгжлийг дэмжих”, “Оюутны хөгжил” хөтөлбөрүүдийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ. | 1. "Залуучуудын хөгжлийг дэмжих хөтөлбөр", "Оюутны хөгжил" хөтөлбөрүүдийг хэрэгжүүлнэ. | | Хөтөлбөрийн хэрэгжилт хувиар | 95 | | Залуучууд, Оюутны хөгжлийг дэмжих чиглэлээр 18 удаагийн нөлөөллийн үйл ажиллагаа, 76 удаагийн сургалт, хөгжлийн бэрхшээлтэй залуучуудад чиглэсэн 10 удаагийн уулзалт, сургалтад 5800 (эм 3200, эр 2600) орчим өсвөр үе, залуучууд, иргэдийн хөгжил оролцоог ханган ажилласан. Мөн 13 сумын нийт 800 гаруй залуучуудыг “Залуучуудын урлаг, спортын бага наадам”, “Оюутан, залуучуудын анхдугаар чуулган” арга хэмжээнд хамруулж, залуучуудын үзэл бодлыг нь сонсож, залуучуудын хөгжлийн төлөөх бодлого, үйл ажиллагаанд тусган ажиллахаар болсон. Аймгийн Залуучуудын хөгжлийн зөвлөлөөс 3000 гаруй залуучуудад 5 удаагийн шууд уулзалт, өдөрлөг, нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулсан. Залуучуудын үндэсний зөвлөлийн 2021 оны 01 дүгээр тогтоолын 17-д зааснаар Төрийн байгууллагын дэргэдэх “Залуучуудын хөгжлийн зөвлөл” нь | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 13 байгууллагад шинэчлэгдэн байгуулагдаад байна. | |
| 3. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО | | | | | | | | |
| 68 | 3.1.2. Санхүү төсвийн хариуцлагыг нэмэгдүүлж зарцуулалтын үр ашгийг сайжруулна. | 1. Аймгийн ТЕЗ-ийн төсвийн багцад хамаарах төсөв захирагчдын батлагдсан төсвөөр хэрэгжүүлэх хөтөлбөр арга хэмжээний зорилт, хүрэх үр дүнг зарцуулсан төсвийн гүйцэтгэлтэй харьцуулан тайлагнах байдлыг сайжруулах | | Нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн үнэлгээ | 92.3 - аас доошгүй | | Аймгийн төсвийн нийт зарлага 75.446,2 сая төгрөг төлөвлөгдсөнөөс 53.305,6 сая төгрөгийн гарсан гүйцэтгэлийг бүрэн санхүүжүүлэн ажиллаж байна. Нийт төсвийн зарлагын  Цалин, нийгмийн даатгалын шимтгэл, эрүүл мэндийн даатгалын хураамжид 58,5%  Тогтмол зардалд 18,3%  Бараа үйлчилгээний бусад зардалд 9,8%  Хөрөнгийн зардалд13,4% байна Аймгийн төсвөөс сумдад олгох санхүүгийн дэмжлэгт 2.059,1 сая төгрөгийг батлагдсан хуваарийн дагуу бүрэн санхүүжүүлэн ажиллаа. | 100% |
| 69 | | 2. Төсвийн хэрэгжилтэд хийх явцын хяналтыг нэмэгдүүлж, зарцуулалтын үр ашгийг сайжруулан санхүүгийн үйл ажиллагаан дахь алдаа зөрчлийг бууруулах. | | Санхүүгийн тайлангийн аудитын стандарт бус дүгнэлт | 0 | | Санхүүгийн тайлангийн аудитын стандарт бус дүгнэлттэй нийт 5 байгууллага байна. Үүнд: Хязгаарлалттай дүгнэлттэй 4 байгууллага / Цагаан-Овоо сумын ЗДТГазар, Хөлөнбуйр сумын ЗДТГазар, БХЗахиргаа, Хэрлэн сумын Чойбалсан Хөгжил ОНӨААТҮГ/, Татгалзсан дүгнэлт 1 байгууллага /Хөлөнбуйр сумын Соёлын төв/ | 30% |
| 70 | | 3. Төсвийн төлөвлөлтөд иргэдийн цаасаар | | Санал өгсөн иргэдийн тоо | | | Төсвийн төлөвлөлтийн дагуу 2022 оны олон нийт иргэдийн оролцоог хангах зорилгоор цахимаар нийт | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | болон цахимаар санал өгөх нөхцөл боломжоор хангаж, оролцоог нэмэгдүүлэх. | | | | | давхардсан тоогоор 30,5000 иргэдээс санал авсан байна. Мөн аймгийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг сумдад ажиллаж цаасаар санал авч ажилласан. | |
| 71 | | 4. Төсвийн гүйцэтгэл, зарцуулалтын талаар олон нийт мэдээлэл авах боломжийг нэмэгдүүлэх . | 2022 | Мэдээлэл хүргэх сувгийн тоо | 4 | | Төсвийн гүйцэтгэл, зарцуулалтын талаар олон нийт мэдээлэл авах боломжийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд Санхүү, төрийн сангийн хэлтсийн пэйж хуудсыг 2022 онд шинээр нээж хэлтсээс хэрэгжүүлж буй арга хэмжээ, аймгийн санхүү, төсвийн гүйцэтгэл, тайлан бүртгэлтэй холбоотой гарсан хууль, тогтоомж заавар журам зэрэг мэдээллийг тоон болон зурган байдлаар цаг тухай бүр нь олон нийтэд цахим сүлжээгээр хүргэж байна. 2022 оны IV улирлын байдлаар 33.6 тэрбум төгрөгийн 181 ажил, үйлчилгээний худалдан авах ажиллагааг зарласнаас 127 ажил үйлчилгээ 54 ажил хийгдсэн байна. Төрийн худалдан авалтын тендер шалгаруулалтыг 100 хувь цахимаар зохион байгуулахаас гадна мэдээллийн самбар, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр дамжуулан худалдан авах ажиллагааны нээлттэй байдлыг ханган ажилласан байна. | 70% |
| 72 | | 5. Аж ахуйн нэгж, байгууллагуудын | | Программ дахь тайлангийн | 90 -ээс доошгүй | | Аж ахуйн нэгж, байгууллагын жилийн эцсийн санхүүгийн тайланг | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | санхүүгийн тайланг Сангийн яамны И-Баланс цахим системд хуулийн хугацаанд хянан баталгаажуулах. | | хамрагдалт (хувиар) | | | Сангийн сайдын 2020 оны 46 тоот тушаалын дагуу "И-баланс" программд цахим хэлбэрээр хүлээн авч, хянан бүртгэлийн алдааг залруулж, арга зүйгээр ханган баталгаажуулсан. 2021 оны жилийн эцэст Сангийн яамны сайтад бүртгэлтэй 1740 байгууллагаас хугацаандаа тайлан илгээсэн нь 1600 байгууллага буюу 92% -ийн ирцтэй, өмнөх оныхоос 2%-иар өссөн дүнтэй байна. | |
| 73 | | 6. Сумдын санхүүгийн албаны үйл ажиллагаанд заавар, зөвлөгөө өгөх, хяналт тавих, зөвлөх үйлчилгээ авах | | Төлөвлөгөөт хяналт хийх сумдын тоо | 7 | | Аймгийн Засаг даргын 2022 оны А/199 захирамжийн дагуу сумдын санхүүгийн албаны 2022 оны үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх, зөвлөн туслах ажлын төлөвлөгөө, удирдамж боловсруулан 2022 оны 05 дугаар сарны 01-18-ны хооронд 13- сумын 81 төсвийн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, 125 аж ахуйн нэгж, байгууллагын 2021 оны нягтлан бодох бүртгэл хөтлөлт, жилийн эцсийн санхүүгийн тайлан гаргалтын байдлыг газар дээр нь үзэж, шалган, заавар зөвлөгөөгөөр зөвлөн туслах үйлчилгээг үзүүлсэн. | 100% |
| 74 | 3.1.3. Төсвийн сахилга батыг сайжруулах, дотоод хяналтыг чангатгах, төсвийн | 1. Шилэн дансан дахь мэдээлэл байршуулалтыг сайжруулах | 2022 | Хэрэгжилтийн хувиар | 95 | | Аймгийн Засаг дарга бөгөөд Төсвийн ерөнхийлөн захирагчийн хамрах хүрээний 170 байгууллагын шилэн дансны цахим мэдээллийн системийн хэрэгжилтийг сайжруулах, шилэн дансны цахим | 70% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | харилцааг бүх шатанд ил тод, нээлттэй байх зарчмыг сайжруулах зорилгоор Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллана. | | | | | | хуудсан дахь мэдээллийг хугацаандаа байршуулах, тайлагнасан эсэх, байршуулсан мэдээллийн агуулга хуулийн шаардлагад нийцэж байгаа эсэхэд хяналтыг бүрэн чиглүүлж ажилласан ба хууль, тогтоомжийн хэрэгжилт 97.5 хувь, цахим системд оруулсан мэдээллийн байршуулалт 85.0 хувь, тайлагналт 100 хувь, нийт хэрэгжилт 92.1 хувьтай байна. | |
| 75 | 3.1.4. Татварын тайлагналт, хураалтын үйл ажиллагааг цахимжуулж, ил тод байдлыг нэмэгдүүлэх замаар татварын үйлчилгээг иргэд, татвар төлөгчдөд хүндрэлгүй болгож, татварын суурийг нэмэгдүүлнэ. | 1. Татвар төлөгчийн ангилал бүрийн онцлог, хууль тогтоомж мөрдөлтийн зан хандлагад нийцүүлсэн сургалт, сурталчилгааны ажлыг олон талт хэлбэрээр зохион байгуулж татвар төлөгчдийн хууль тогтоомжийн мөрдөлтийн түвшинг дээшлүүлэх. | 2022 | Сургалт,арга хэмжээний тоо | 24 | | Татвар төлөгчийн борлуулалтын орлогын дүнгээс хамаарч сегментийн ангилалд хуваан сегментийн бодлогыг хэрэгжүүлэн ажиллалаа. Татвар төлөгчдийн хууль тогтоомжийн мөрдөлтийн зан хандлагыг дээшлүүлэх ажлын хүрээнд 4-р загварчлалын татвар төлөгчдөд 22 удаагийн цахим болон танхимын сургалтыг зохион байгуулж, 320 татвар төлөгчийг хамрууллаа. Тайлант хугацаанд хууль мөрдөлтийн загварчлал 4 дүгээр ангиллын татвар төлөгчийн тоо хувиар 6.2 хувиар буурч 161 татвар төлөгч байна. | 90% |
| 76 | | 2. Аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлж буй бусад татварын албанд бүртгэлтэй татвар төлөгчдийг бүртгэх ажлыг | 2022 | Төсвийн орлогын биелэлт хувиар | 100 | | Тайлант хугацаанд тус аймгийн нутаг дэвсгэрт ашигт малтмал олборлох чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж байгаа “Степ голд” ХХК, “Меланж” ХХК-тай ажил гүйцэтгэх гэрээ байгуулсан бусад аймаг, дүүрэгт бүртгэлтэй 6 аж ахуй | 70% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | зохион байгуулж татварын суурийг нэмэгдүүлнэ. | | | | | нэгжийг тус татварын хэлтэст бүртгүүлэх талаар уулзалт зохион байгуулж, татварын хууль тогтоомжийн талаар мэдээлэл өгснөөр “Меланж” ХХК-ний туслан гүйцэтгэгч “Вертекс майнйнг партнер” ХХК, “Эм Вай Си” ХХК, “Зууннайман ойл” ХХК нь цалин, хөдөлмөрийн хөлс, тэдгээртэй адилтгах орлогоос суутгасан албан татвар төлөгчөөр тус хэлтэст бүртгүүлж 43.5 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлээд байна. ААНОАТ-ын дахин хуваарилалтаар Меланж ХХК-ийн туслан гүйцэтгэгч Кэй Эй групп ХХК-ийн төлсөн аж ахуйн нэгжийн орлогын албан татвар 2147.7 мянган төгрөг хуваарилагдсан байна. | |
| 77 | 3.1.5. Санхүүгийн ажилтнуудын мэдлэг, ур чадвар, ажиллах нөхцөлийг сайжруулахад дэмжлэг үзүүлж, "Сайн санхүүч" хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. | 1. Төрийн сангийн үйл ажиллагааны цахим шилжилт, цахим архив, портал системд 2022 оноос шилжих ажлын хүрээнд сумдын санхүүгийн алба, орон нутгийн төсөвт байгууллагуудын санхүүгийн ажилтнуудын ажиллах нөхцөлийг сайжруулах зорилгоор нягтлан бодох бүртгэлийн | 2022 | Онлайн программын тоо | 110 | | Төрийн сангийн үйл ажиллагааны цахим шилжилт, хүрээнд аймгийн орон нутгийн төсвийн 22.5 сая төгрөгийн хөрөнгөөр 14 сумдын санхүүгийн алба, орон нутгийн төсөвт байгууллагуудад цахим орчинд ажиллах бүртгэлийн Динамик программаар 100 хувь хангаж орон зай хамааралгүйгээр ажиллах нөхцөлийг бүрэн бүрдүүлсэн. | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | программд өргөтгөл хийж онлайн болгож цахим орчинд ажиллах нөхцөлийг бүрдүүлнэ. | | | | | | |
| 78 | | 2. Төрийн сангийн үйл ажиллагаа 2022 оноос цахимд шилжих бэлтгэл ажлын хүрээнд Санхүү, төрийн сангийн хэлтсийн ажилтнуудын ажиллах нөхцөлийг сайжруулах тоног төхөөрөмжийн шинэчлэлт хийх. | 2022 | Шинэчлэгдсэн тоног төхөөрөмжийн тоо | 4 | | Аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжих “Цахим сургалтын компьютер, тоног төхөөрөмж худалдан авах” ажлын хүрээнд 3 ширхэг тоног төхөөрөмжийг 12.0 сая төгрөгөөр Санхүү, төрийн сангийн хэлтэст худалдан авсан. Үүнд: Зөөврийн компьютер 1, ухаалаг дэлгэц 1, суурин компьютер-1. | 100% |
| 79 | | 3. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт шинэчлэл хийх. | 2022 | НББББичиг шинэчлэгдсэн тоо | 1 | | Аймгийн хэмжээнд Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт шинэчлэл хийх ажил эрчимтэй явагдаж, “Дорнод НАА” ОНӨААТҮГазрын НБББББ бүрэн шинэчлэгдэж дууссан. “Чойбалсан хөгжил” ОНӨААТҮГазрын НБББББ шинэчлэгдэн, дуусах шатандаа, Жижиг аж ахуйн нэгж, байгууллагуудыг шинээр НБББББичигтэй болгох ажил явагдаж, эхний ээлжинд сумдын 82 аж ахуйн нэгж, байгууллагыг сургалтад хамруулж, үнэгүй заавар, зөвлөгөөгөөр хანган, ажиллаж байна. | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 80 | | 4. Бүх шатны төрийн байгууллагын сургалтыг цахимаар зохион байгуулах болсонтой холбогдуулан сургалтын тоног төхөөрөмж авах | 2022 | Тоног төхөөрөмжийн тоо | 1 | | Аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжих “Цахим сургалтын компьютер, тоног төхөөрөмж авах” ажлын хүрээнд 5 ширхэг тоног төхөөрөмжийг 16.0 сая төгрөгөөр худалдан авсан. Үүнд: Зөөврийн компьютер 1, , ухаалаг дэлгэц 1, Веб Камер 1, Хурлын микрофон / USB /, Speaker Edifier | 100% |
| 81 | | 5. Компьютер, тоног төхөөрөмж /Санхүүгийн хяналт, аудитын алба/ | 2022 | Тоног төхөөрөмжийн тоо | 1 | | Аймгийн Орон нутгийн төсвийн 19.5 сая төгрөгийн хөрөнгөөр Дотоод аудиторуудын ажлын байрны материаллаг орчныг сайжруулж, орчин үеийн шаардлагад нийцсэн 5 сурин, 1 зөөврийн компьютерийг худалдан авч өгсөн. | 100% |
| 82 | | 6. "Татан төвлөрүүлсэн тээврийн хэрэгслийг түр хадгалах объект"-ын камержуулалт /Орон нутгийн өмчийн газар/ | 2022 | Тоног төхөөрөмжийн тоо | 1 | | Аймгийн Засаг даргын 2022 оны А/438 дугаар захирамжаар байгуулагдсан комисс 2022 оны 09 дүгээр сарын 09-ны өдрийн Хэрлэн сумын 3 дугаар багт байрладаг Орон нутгийн өмчийн газрын аж ахуйн хашаанд “Татан төвлөрүүлсэн тээврийн хэрэгслийг түр хадгалах объектын камержуулалтыг (Орон нутгийн өмчийн газар)” байршуулсан. | 100% |
| 83 | 3.1.6. Орон нутгийн өмчийн ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, | 1. Өмч эзэмшлийн гэрээг шинэчлэн байгуулж, дүгнэх аргачлалыг өөрчлөх. | 2022 | Орон нутгийн өмчит бүх хуулийн этгээдийг хамруулсан байх | 157 | | Өмч эзэмшлийн гэрээг шинэчлэн, дүгнэх аргачлалыг өөрчлөн ажиллаж. 2021 оны жилийн эцсийн дүнгээр гэрээг байгуулан ажиллаж | 90% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | өмчийн бүртгэл мэдээллийг цахимжуулан орон нутгийн өмчийн хяналтын тогтолцоог боловсронгуй болгоно. | | | | | | байна. Гэрээ байгуулах явц 100 хувьтай байна. | |
| 84 | | 2. Төрийн болон орон нутгийн өмчийн улсын үзлэг, тооллогын ажлыг зохион байгуулж, дүнгийн мөрөөр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх. | 2022 | Эд хөрөнгийн улсын үзлэг тооллогын зохион байгуулж, зөрчил дутагдлыг арилгуулах арга хэмжээг авсан байх | 1 | | Аймгийн Засаг даргын 2022 оны А/178 дугаар захирамжаар орон нутгийн өмчийн улсын үзлэг тооллогыг зохион байгуулах салбар комиссыг байгуулж, улсын үзлэг тооллого зохион байгуулах бэлтгэл ажлын төлөвлөгөөг батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Дээрх ажлын хэсэг орон нутгийн өмчит 158 байгууллагын санхүүгийн асуудал хариуцсан 187 албан хаагч нарт төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг тооллогыг зохион байгуулах, тооллогын программд хөрөнгийн мэдээллийг шивэн оруулах сургалтыг 2022 оны 04 дүгээр сарын 19-20–ны өдрүүдэд зохион байгуулсан. Мөн аймгийн Засаг даргын 2022 оны 1/1088 дугаар албан бичгээр орон нутгийн өмчит 158 байгууллагад чиглэл хүргүүлж, 120 гаруй байгууллагад арга зүйн зөвлөгөө өгч ажиллаж байна. Одоогийн байдлаар орон нутгийн өмчийн улсын үзлэг, тооллого 100 хувьтай бүрэн дууссан. Улсын үзлэгийн дүн мэдээг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт нэгтгүүлсэн. Улсын үзлэг тооллогоор гарсан | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | зөрчил дутагдлыг арилган ажилласан. | |
| 85 | 3.2.1. Мал аж ахуйг эрсдэлээс хамгаалах зорилгоор аймаг сумын өвс тэжээлийн аюулгүйн нөөц бүрдүүлэх ажлыг зохион байгуулна. | 1. Аймаг, сумын өвс тэжээлийн аюулгүйн нөөц бүрдүүлнэ. | | Аюулгүйн нөөцийн хэмжээ | Өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлыг хангах шийдвэрт тогтоосон хэмжээ | | Хөдөө аж ахуйн салбарын 2022-2023 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах  Монгол Улсын Засгийн газрын 277 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 05 дугаар албан даалгаврын хүрээнд аймаг, сумын өвс, тэжээлийн аюулгүй нөөцийг бүрдүүлэн ажиллаж байна. Үүнд: Аймгийн аюулгүй нөөцөд 150 тн өвс бэлтгэхээс 167,4 тн өвс буюу 111,6 хувьтай, 40 тн тэжээл бэлтгэхээс 73,5 тн тэжээл бэлтгэж 183,7 хувь, аймгийн аюулгүй нөөц нийт 147,6 хувь, 1120 тн өвс, 420 тн тэжээл бэлтгэхээс 1403.4 тн өвс, 275 тн тэжээл бэлтгэж дунджаар 95.2 гүйцэтгэлтэй байна. Малчдын түвшинд 107,321 тн өвс бэлтгэхээс 94,659,9 тонн бэлтгэж 88,2 хувь, 470 тн тэжээл бэлтгэхээс 379 тонн бэлтгэж 80,6 хувь, малчдын түвшинд бэлтгэх өвс тэжээл нийт 84,4 хувьтай байна. | 90% |
| 86 | | 2. Уул уурхай, газрын тосны болон түгээмэл тархацтай ашигт малтмалын нөлөөлөлд өртөж буй малчид, иргэдэд өвс тэжээлийн дэмжлэг үзүүлэх. | 2022 | Бэлтгэх өвс, тэжээлийн хэмжээ | 80 тн өвс, 14.7 тн тэжээл | | Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтээр Түгээмэл тархацтай ашигт малтмал, уул уурхайн нөлөөлөлд өртөж буй Хэрлэн сумын 1, 2, 3, 5, 8, 10 дугаар багийн 205 малчин өрхөд 144 тонн өвс тэжээлийн дэмжлэг үзүүлсэн | 70% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 87 | | 3. Жилийн эцсийн мал тооллогын ажлыг зохион байгуулна. | 2022 | Малын тоо толгой /Өссөн дүнгээр/ | 3.1 | | 2022 оны жилийн эцсийн байдлаар 3.342.000 /гурван сая гурван зуун дөчин хоёр мянган/ мал тоологдсон. | 100% |
| 88 | 3.2.2. Бэлчээрийг усжуулах ажлыг үргэлжлүүлэн малын бэлчээрийн нөөцийг нэмэгдүүлэх | 1. Хил хамгаалах туслах хүчинд дайчлагдан ажиллаж байгаа малчин өрхийн бэлчээрийн усан хангамжийг сайжруулах, дэмжлэг үзүүлэх зорилгоор худаг уст цэг, цооног гаргах. | 2022 | Цооногийн тоо | 9 | | Орон нутгийн төсвийн 2021 оны санхүүжилтээр Баянтүмэн суманд 1, Булган суманд 3, Матад суманд 2, Халхгол суманд 3 нийт 9 ширхэг Хил хамгаалах туслах хүчинд дайчлагдан ажиллаж байгаа малчин өрхийн бэлчээрийн усан хангамжийг сайжруулах зорилгоор инженерийн хийцтэй, гүн өрмийн цооног шинээр гаргах ажлыг гүйцэтгэгч аж ахуй нэгж 6 ширхэг цооног гарган дуусгаж ашиглалтад оруулан комисст хүлээлгэн өгөөд байна. | 70% |
| 89 | 3.2.3. Газар тариалан бэлчээр хадлан, тэжээлийн талаар баримтлах бодлогын хэрэгжилтэд хяналт тавьж хэрэгжилтийг хангуулах | 1. “Газар тариалан, бэлчээр, хадлан тэжээлийн талаар баримтлах бодлого”-ыг хэрэгжүүлэн хяналт тавина. | 2022 | Хэрэгжилтийн явц хувиар | 100 | | Аймгийн хэмжээнд 2022 онд 11 сумын ИТХ-аар 76.6 мянган га газарт үйлдвэрлэлийн хадлан бэлтгэхээр баталж 10 суманд 10 аж ахуй нэгж, 151 иргэн 24.5 мянган га талбайд үйлдвэрлэлийн зориулалтаар хадлан бэлтгэсэн ба бодлогын хэрэгжилтийг хангуулан сумдад газар дээр хяналт тавьж ажилласан. | 100% |
| 90 | | 2. Малчдын зөвлөгөөн-2022 арга хэмжээг зохион байгуулах. | 2022 | Зөвлөгөөнд оролцсон малчдын тоо | 300 малчин өрхийг хамруулна | | Аймгийн Засаг даргын тамгын газар, аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар “Монгол орны хөдөөгийн иргэдийн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадамж | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | болон эрсдэлийн менежментийг боловсронгуй болгох нь” төсөлтэй хамтран “Малчдын зөвлөгөөн-2022” нэгдсэн арга хэмжээг зохион байгуулсан. Зөвлөгөөнд нийт 330 гаруй малчин өрхийг хамруулсан. | |
| 91 | 3.2.4. Атрын IV аяныг хэрэгжүүлж, тариалангийн тогтвортой үйлдвэрлэлийн хөгжлийг хангаж, бүтээгдэхүүнийг экспортлох, боловсруулах хүчин чадлыг нэмэгдүүлж, тarимлын сэлгээ, тэжээл үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх замаар салбарын бүтээмж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлнэ. | 1. Газар тариалангийн үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний төрөл, тариалах талбайг нэмэгдүүлнэ. | 2022 | Тариалах талбай /мянган га/, Таримлын төрөл /тоо/ | 33, 8 | | Аймгийн хэмжээнд нийт үр тариа 35,290 га-аас 36,518 тн ургац хураан аваад байна. Үүнээс улаан буудай 24,095 га-аас 281,265 тн, төмс 162,9 га-аас 1442,3 тн, хүнсний ногоо 180 га-аас 1489,8 тн бусад үр тариа 3940 га-аас 3081 тн тосны ургамал 5880 га-аас 3044 тн, малын тэжээл 930 га-аас 1388 тн ургац тус тус хураан авч нийт ургац хураалт 100 % явагдаж байна. | 100% |
| 92 | | 2. Хүлэмжийн аж ахуйн хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. | 2022 | Нийлүүлэх хүлэмжийн тоо | 100 | | Орон нутгийн төсвийн 517 сая төгрөгийн санхүүжилтээр 311 хүлэмж худалдан авах арга хэмжээг зохион байгуулж хүнсний ногооны өрхийн тариалан эрхлэгч, иргэдэд олгож хамгаалагдсан хөрсний тариалалтыг 10.7 мянган мкв талбайгаар нэмэгдүүлсэн. | 100% |
| 93 | | 3. Өрхийн тариалан эрхлэгчдэд технологийн сургалт зохион байгуулах, хүнсний ногоо дэд хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана. | 2022 | Зохион байгуулсан сургалтын тоо, Хяналтын үр дүнд зөвлөмж боловсруулсан эсэх | 4, 1 | | “Хүнсний ногоо” дэд хөтөлбөрийн хүрээнд хүнсний ногооны тариалан эрхлэгч иргэд, аж ахуй нэгж, төрийн болон төрийн бус байгууллагуудын төлөөлөл зэрэг нийт 160 гаруй иргэдэд сургалт, зөвлөгөөнийг зохион байгуулан ажилласан. | 70% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 94 | 3.2.5. Бичил, жижиг, дунд үйлдвэр, бизнес эрхлэгчдийг бизнес инкубацын үйлчилгээгээр бойжуулан санхүүгийн дэмжлэг үзүүлж, чадавхыг бэхжүүлэн, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлнэ. | 1. Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих чиглэлээр үйл ажиллагаа эрхлэгч иргэн, аж ахуй нэгжийг хөнгөлөлттэй зээлд хамруулна. | | Зээлд хамрагдсан аж ахуйн нэгжийн тоо | 600 | | “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас зээл олгох, сонгон шалгаруулах, дамжуулан зээлдүүлэх, эргэн төлүүлэх, хяналт тавих” журмын дагуу хөнгөлөлттэй олгох зээлд 3 аж ахуй нэгжид 200,0 сая төгрөгийн зээл олгосон байна. Зах зээл ба бэлчээрийн удирдлага хөгжил төслийн хөнгөлөлттэй зээлд 8 сумын 64 иргэнд 774,5 сая төгрөг, 3 аж ахуйн нэгжид 185,0 сая төгрөг нийт 959,5 сая төгрөгийн зээлийг олгосон байна. Хоршоог хөгжүүлэх сангийн зээлд 5 сум 12 төсөлд 460,5 сая төгрөгийн зээл олгосон. 2022 онд нийт 82 иргэн, аж ахуйн нэгж 1,6 тэрбум төгрөгийн зээлд хамрагдсан байна. | 100% |
| 95 | | 2. Мэргэжлийг холбоодын үйл ажиллагааг чадавхжуулах. | | Хамтын ажиллагаа сайжирсан эсэх | 1 | | Эдийн засгийн хөгжлийг дэмжих, төрийн байгууллага, мэргэжлийн холбоодын хамтын ажиллагааг сайжруулах зорилгоор “Мэргэжлийн холбоодын анхдугаар зөвлөгөөн”-ийг зохион байгуулж 150 төлөөлөл оролцож 16 холбооны төлөөлөлтэй хамтын ажиллагааны санамж бичиг байгуулсан. Мөн 16 мэргэжлийн холбоодыг үйл ажиллагааны чиглэлээр нь ангилан 4 хэсэгт хуваан нарийн бичигтэй болгосон. | 100% |
| 96 | 3.2.6. Мал амьтны халдварт өвчинтэй | 1. Мал, амьтны халдварт өвчнөөс урьдчилан | | Хамрагдах мал амьтны тоо, толгой | 369.5 | | Аймгийн Засаг даргын 2022 оны А/102 дугаар захирамж, Мал эмнэлгийн газрын даргын 2022 оны А/09 дугаар тушаалын хүрээнд | 70% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээ | сэргийлэх арга хэмжээ. | | | | | мал, амьтны /цусан халдварт, ДХХ, шөвөг яр, энтеробактериоз, гахайн мялзан/ халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 369,200 толгой мал хамруулахаас 291,250 толгой мал хамруулж 80 хувьтай хамруулан ажилласан. | |
| 97 | | 2. Мал, амьтан, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэхэд шаардагдах эм бэлдмэлийн зардал. | 2022 | Зарцуулагдах эм бэлдмэлийн тоо хэмжээ /мл.тун/ | 2455.6 | | Биокамбинет төрийн өмчит ХХК-тай байгуулсан вакцин, эм биобэлдмэл худалдан авах гэрээний дагуу 2.4 тн вакцин, эм био бэлдмэлийг 100 хувь нийлүүлээд байна. Тус эм биобэлдмэлийн зардалд зарцуулагдах 82.2 сая төгрөгийн санхүүжилтийг орон нутгийн төсвөөс 100 хувь шийдвэрлэсэн. | 100% |
| 98 | 3.2.7. Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төслөөс Дорнод аймагт хийгдэх хөрөнгө оруулалтын 50 хувь /бүх сумдад/ төслөөс 50 хувь | 1. Мал угаах суурин ванн шинээр барих /Баяндун, Баян-Уул, Булган, Гурванзагал, Дашбалбар, Матад, Сэргэлэн, Чойбалсан, Чулуунхороот сумд/ | | (тийм,үгүй) | 8 | | Орон нутгийн хөгжлийн сан болон Зах зээл ба бэлчээрийн удирдлага төслийн санхүүжилтээр Баяндун-1, Баян-Уул-2, Булган-1, Гурванзагал-1, Дашбалбар-1, Матад-1, Сэргэлэн-1, Чойбалсан-1, Чулуунхороот-1 нийт 9 суманд 10 ширхэг мал угаах суурин ванн шинээр барьж ашиглалтад оруулан комисст хүлээлгэн өгөв. | 100% |
| 99 | | 2. Хүнсний ногооны зоорь шинээр барих/ Баян-Уул сум | | Ажил хэрэгжсэн эсэх (тийм,үгүй) | 1 | | Орон нутгийн хөгжлийн сан болон Зах зээл ба бэлчээрийн удирдлага төслийн санхүүжилтээр Баян-Уул суманд “Хүнсний ногооны зоорь шинээр барих” ажил хийгдэж ашиглалтад оруулан комисст хүлээлгэн өгөв. | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 100 | | 3. Өвс, тэжээлийн агуулах саравч шинээр барих. | 2022 | Ажил хэрэгжсэн эсэх (тийм,үгүй) | 3 | | Орон нутгийн хөгжлийн сан болон Зах зээл ба бэлчээрийн удирдлага төслийн санхүүжилтээр Булган, Гурванзагал, Цагаан-овоо сумдад өвс, тэжээлийн агуулах саравч шинээр барих ажил хийгдэж ашиглалтад оруулан комисс хүлээлгэн өгсөн. | 100% |
| 101 | | 4. Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих төвийг засварлаж ашиглалтад оруулах. | | Засварлаж ашиглалтад оруулсан эсэх | 1 | | Зах зээл ба бэлчээрийн удирдлага төслийн хөрөнгөөр байгуулагдсан Халхгол, Хөлөнбуйр, Хэрлэн сумын Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих төвд 2022 онд шинээр 4 бизнес эрхлэгчийг авч нийт 15 үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчид үйл ажиллагаа явуулж байна. Баян-Уул сумын Эрээн багийн Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих төвийн байрны засварын ажил хийгдэж хүлээлгэн өгсөн. | 100% |
| 102 | | 5. Хүнсний ногооны зоорь засварлах. | | Засвар хийсэн зоорийн тоо | 3 | | Орон нутгийн хөгжлийн сан болон Зах зээл ба бэлчээрийн удирдлага төслийн санхүүжилтээр Булган, Гурванзагал, Сэргэлэн сумдад хүнсний ногооны зоорийн засварын ажил хийгдэж ашиглалтад хүлээлгэн өглөө. | 100% |
| 103 | | 6. Газар тариалангийн газрыг усжуулах системийг засварлах. | 2022 | Засварласан системийн тоо | 2 | | Орон нутгийн хөгжлийн сан болон Зах зээл ба бэлчээрийн удирдлага төслийн санхүүжилтээр Баянтүмэн, Гурванзагал сумдад тус бүр 4 га газарт төмс, хүнсний ногооны талбайн услалтын систем | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | засварлах ажил хийгдэж ашиглалтад хүлээлгэн өгсөн. | |
| 104 | 3.3.1. Аялал жуулчлалын салбарын дэд бүтцийг сайжруулж, жуулчин хүлээн авах хүчин чадлыг нэмэгдүүлэх, нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг боловсронгуй болгон бусад салбартай уялдуулан хөгжүүлж, эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлнэ | 1. Аялал жуулчлалын улирлын нээлт, хаалтын үйл ажиллагааг хавар, намрын улиралд зохион байгуулна. | | Арга хэмжээ тоо | 4 | | Аялал жуулчлалын улирлын нээлт, хаалтын үйл ажиллагааг 11 сарын 05-06-ны өдрийн хооронд зохион байгууллаа. Тодорхой зорилго,зорилтын хэрэгжүүлэн дэвшүүлж Орон нутгийн аялал жуулчлалын бизнес эрхлэгчид болон аялал жуулчлалын байгууллага, тур оператор компаниудтай хамтран уулзалт хийж мэдээлэл солилцон гэрээ байгуулах боломжийг нээж өгөх, аялал жуулчлалын мэргэжлийн байгууллага байршуулах үйлчилгээ тур операторын уялдаа холбоог сайжруулах, тур оператор компаниудад Дорнод нутгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг санал болгон танилцуулах, маршрутыг эргэлтэд оруулж гадаад, дотоодын жуулчдын урсгалыг нэмэгдүүлэх талаар ярилцан хэлэлцэв. Улаанбаатар хотод Монгол Улсын Аялал жуулчлалын зочин тур оператор компаний захирлуудтай зангиагүй уулзалт хийж тодорхой 4-н төслийг боловсруулж хамтран хэрэгжүүлэх шийдэлд хүрэв. | 70% |
| 105 | | 2. Хөрш зэргэлдээ гурван улсын аялал жуулчлалын өдрийг зохион байгуулна. | | Арга хэмжээ тоо | 5 | | Хил гааль хаалттайгаас үүсэлтэй арга хэмжээ зохион байгуулагдаагүй | 0% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 106 | | 3. Аймгийн тахилгат уул, овоо, ус, гол мөрний тахилга зохион байгуулна. | | Эдийн засгийн үзүүлэлтийн өссөн эсэх | 1 | | Аймгийн Засаг даргын 2022 оны А/185 дугаар захирамжаар аймгийн тахилгат Хан-Уул, Дэлгэрмөнх уул, Галын голын тахилгын арга хэмжээг зохион байгуулсан. | 100% |
| 107 | | 4. Дорнод аймгийн аялал жуулчлалын үндсэн 9 маршрутыг эдийн засгийн эргэлтэд оруулна. | | Эдийн засгийн үзүүлэлтийн өссөн эсэх | 1 | | Дорнод аймгийн аялал жуулчлалын албан ёсны цахим хуудас http://travel.dornod.gov.mn/-д мэдээллийг байршуулан ажиллаж байна. | 30% |
| 108 | 3.3.2. Хүн амын ундны усны хэрэгцээг хангах | 1. Буйр нуурын эрэг дагуу ундны усны худаг гаргах | 2022 | Гаргасан худгийн тоо | 2 | | Орон нутгийн хөгжлийн сангийн 60,0 сая төгрөгийн санхүүжилтээр Халхгол сумын Ялалт баг Буйр нуурын эрэг дагуу ундны усны 2 ширхэг, гүн өрмийн худаг шинээр гаргах цэвэршүүлэх тоног төхөөрөмжийг суурилуулах ажилд“Топ дриллинг ХХК” гүйцэтгэгчээр шалгарч ба ажлын гүйцэтгэл 80 хувьтай явагдаж байна. | 70% |
| 109 | 3.4.1. Уул уурхайн салбарын үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулна. | 1. Нөхөн сэргээлт хийдэг, дэвшилтэт технологи нэвтрүүлдэг, усыг дахин ашигладаг, байгалийн нөөц ашигласан төлбөрөө хугацаандаа төлдөг хариуцлагатай уул уурхайг дэмжинэ. | | Гэрээний хэрэгжилтийг дүгнэсэн тоо | Хариуцлагатай уул уурхайг нэмэгдүүлнэ | | Тус аймгийн нутагт 2022 оны эхний хагас жилийн байдлаар 8 аж ахуйн нэгж ашиглалтын үйл ажиллагаа явуулж байна. Газрын хэвлийн нөхөн сэргээлтийн ажлыг тайлант онд нь багтаан төлөвлөсөн ажлын хэмжээг бүрэн хийлгэхээр Байгаль орчин, аялал жуулчлалын газар болон аймгийн Засаг даргын 2020 оны А/500 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг ажиллаж байна. | 30% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 110 | | 2. Уул уурхайн ашиглалтын талбай, тээвэрлэлтийн замыг нөхөн сэргээх ажлыг эрчимжүүлэн орчны бохирдол доройтлыг бууруулж, экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалж, ашиглалтын технологийн зам барих ажлыг эхлүүлнэ. | | Ашиглалтын технологийн зам барих ААН-ийн тоо | 3 | | Гадаадын хөрөнгө оруулалттай “Шинь Шинь”ХХК-ийн уул уурхайн бүтээгдэхүүн тээвэр хийж байгаа нийт 124 км замын ашиглалтад 2022 оны 1 дүгээр сард хяналт шалгалтын ажлыг зохион байгуулсан. Орон нутгийн Автотээврийн төв, Мэргэжлийн хяналтын газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газраас уул уурхай бүтээгдэхүүн тээвэрт ашиглагдаж байгаа замыг бүрэн барьж дуусган, ашиглалтад оруулах үүргийг “Шинь шинь” ХХК-д өгч ажиллаад байна. Мөн тээврийн хэрэгслийн маршрутын дагуу явж байгаа эсэхэд хяналт тавьж, замын хажуугаар байгалийн хөрс эвдрэлд оруулахгүй байхыг анхааруулж чиглэл өгсөн. | 50% |
| 111 | | 3. Аймгийн хэмжээнд бичил уул уурхайтай холбоотой асуудлыг цэгцэлж, шинээр бичил уул уурхай байгуулахгүй байх бодлогыг үргэлжлүүлэн баримтална. | | Бичил уурхай эрхлэгчийн тоо | 0 | | Баяндун суманд үйл ажиллагаа явуулж байсан “Улз Баяндун андууд” нөхөрлөл олборлолтын үйл ажиллагаа зогссон бөгөөд нөлөөлөлд өртсөн 5 га газраас 2,5 га талбайд нөхөн сэргээлт хийгээд байна. Бичил уул уурхайтай холбоотойгоор шинээр нөхөрлөл болон хоршоо байгуулагдаагүй болно. | 100% |
| 112 | 3.4.2. Уул уурхай, газрын тосны үйл ажиллагаанаас | 1. Байгаль орчныг хамгаалах, уул уурхай, газрын тосны төслүүдээс | | Гэрээ байгуулах ААН-ийн тоо | 24 | | 2022 оны байдлаар 19 аж ахуйн нэгж байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллаж байна. | 70% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | орон нутгийн хөгжил, иргэдэд үзүүлэх үр өгөөжийг нэмэгдүүлнэ. | орон нутгийн хөгжилд оруулах хувь нэмрийг нэмэгдүүлэх, уул уурхайн тасралтгүй хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй хамтран ажиллах гэрээг байгуулж ажиллана. | | | | | | |
| 113 | | 2. Орон нутгийн үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээ эрхлэгч иргэн, аж ахуйн нэгжүүдийг уул уурхай, газрын тосны үйл ажиллагаанд давуу эрхтэйгээр бараа, ажил үйлчилгээ нийлүүлэх боломжийг нэмэгдүүлнэ. | | Бараа, ажил үйлчилгээ нийлүүлэх ААН-ийн тоо | 7 | | Матад сумын малчид 25,5 тн мах, аймгийн Зөгийчдийн холбооноос 1149 кг зөгийн бал нийлүүлсэн байна. | 50% |
| 114 | | 7. Төрийн захиргааны байгууллага, тусгай зөвшөөрөл эзэмшигч нартай хамтран уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрлэлийн | | Сургалтын сангийн тэтгэлэгт хамрагдсан оюутны тоо | 15 | | Аймгийн ХАБЭА-н зөвлөлөөс 2022 оныг “Эрсдэлийг бууруулах жил” болгон зарлахтай холбогдуулан уул уурхай, эрдэс баялгийн салбарын аж ахуйн нэгж, байгууллагуудын удирдлагуудад байгууллагад эрсдэлийн үнэлгээ хийлгэх, зөвлөн туслах үйлчилгээ авах, ХАБЭА-н | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | салбарын мэргэжилтэй ажилтныг сурган дадлагажуулах, ажиллах хүчнийг орон нутгаас хангах бодлого баримтална. | | | | | багц сургалтуудыг зохион байгуулах талаарх чиглэл, зөвлөмжийг 2 удаа хүргүүлж, орон нутгаас энэ чиглэлээр үйлчилгээ үзүүлэх, сургалт зохион байгуулах эрх бүхий сургалтын байгууллагатай хамтран ажиллахыг зөвлөсний дагуу "Шинь Шинь" ХХК, "Адуунчулуун" ХК, Петрочайна Дачин тамсаг 19-р талбай дахь туслан гүйцэтгэгч "Дорнын хөгжил" ХХК, "Найнги" ХХК, "Степ Голд" ХХК, "Тун Гуан Майнз" ХХК, "Петрочайна Дачин тамсаг" ХХК-иудад аймгийн политехник коллежийн 10 ангийн 192 оюутнууд танилцах, үйлдвэрлэлийн, төгсөлтийн өмнөх дадлагууд хийгдэж байна. | |
| 115 | | 4. Уул уурхай, газрын тосны гэрээнд хяналт тавих, Хамтын ажиллагааны хорооны үйл ажиллагааг сайжруулах | | Үнэлж дүгнэсэн гэрээний тоо | 18 | | Уул уурхай, газрын тосны 12 гэрээнд хяналт тавин хамтран ажилласан | 70% |
| 116 | 3.4.3. Уул уурхайн салбарын хууль, тогтоомж бодлогын хэрэгжилтийг орон нутагт | 1. Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн 30-аас доошгүй хувийг тухайн ашиглалт явагдаж буй аймаг, суманд хуваарилах хуулийн | | Хуулийн хэрэгжилт хангагдсан эсэх | Суурь түвшинг нэмэгдүүлэх | | Газрын тосны тухай хуулийн 31.3. "Нөөц ашигласны төлбөрийн 30 хувийг тухайн орон нутгийн хөгжлийн нэгдсэн санд, 70 хувийг улсын төсөвт тус тус төвлөрүүлнэ" гэсэн заалтын дагуу Сангийн яамыг нэхэмжлэгчээр татан 2 удаагийн шүүх хуралд оролцож, Ашигт | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | хангаж ажиллана. | хэрэгжилтийг хангуулах талаар идэвхи санаачлагатай ажиллана. | | | | | малтмалын нөөц ашигласны төлбөрийн 30 хувийг тухайн аймаг, суманд хуваарилах асуудлыг холбогдох яам, орон нутгаас сонгогдсон УИХ-ын гишүүдэд удаа дараа хүргүүлж ажилласнаар орон нутгийн хөгжийн санд ордог 3.8 хувийг 13.6 хувь буюу 2.2 тэрбум төгрөг болгон нэмэгдүүлсэн. | |
| 117 | | 2. Уул уурхай, газрын тосны төсөл эхлэхээс өмнө байгаль орчин, нийгэм, эдийн засгийн үнэлгээ хийдэг байх эрх зүйн зохицуулалтыг бий болгоход санаачилгатай ажиллана. | | Эрх зүйн зохицуулалтыг эрх бүхий байгууллагаар шийдвэрлүүлсэн эсэх | 1 | | Тайлант хугацаанд ажил зохион байгуулагдаагүй байна. | 0% |
| 118 | | 3. Уул уурхайн лицензийн талаарх мэдээллийг олон нийтэд нээлттэй болгож, хууль зөрчиж олгосон зөвшөөрлийг хүчингүй болгуулах талаар идэвхтэй ажиллана. | | Уул уурхайн лицензийн талаарх мэдээллийг олон нийтэд нээлттэй хүргэх төрлийн тоо | 3 | | Тайлант онд хугацаанд уул уурхайн аж ахуйн нэгжүүд үйл ажиллагааны талаар мэдээллийг гэрээнд заасан хугацаанд иргэдэд үе шаттай танилцуулан ажиллаж байна.Аж ахуйн нэгжүүдийн хувьд гэрээний хүрээнд хариуцлагатай ажилласан тул тусгай зөвшөөрлийг цуцлуулах санал хүргүүлээгүй. | 30% |
| 119 | | 4. Улсын төсвийн хөрөнгөөр хийгдэх геологийн, | | Дэмжлэг үзүүлсэн ажлын тоо | 5 | | Аймгийн Засаг дарга, Уул уурхайн сайдтай байгуулсан гэрээний дагуу эрдэс баялгийн нөөцийг | 30% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | судалгааны ажлыг эрчимжүүлж, эрдэс баялгийн нөөцийг нэмэгдүүлэхэд орон нутгийн зүгээс дэмжлэг үзүүлж ажиллана. | | | | | нэмэгдүүлэх талаар яамнаас ирүүлсэн чиглэлийн дагуу холбогдох судалгааны ажлыг дэмжихийг сумдад уламжилсан. | |
| 120 | 3.5.1. Цахилгаан, дулааны эрчим хүчний үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэн, өсөн нэмэгдэж байгаа хэрэгцээг дотоодоос бүрэн хангах нөхцөлийг бүрдүүлнэ. | 1. Чойбалсангийн дулааны цахилгаан станцын хүчин чадлыг 50 мвт-аар өргөтгөх ажлыг үргэлжлүүлнэ. | | Төслийн явц хувиар | 100 | | Тус ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендер ЭХЯаманд зохион байгуулагдаж, гүйцэтгэгчээр “Энх өглөө” ХХК шалгаран ажил гүйцэтгэх гэрээг байгуулан ажиллаж байна. Өргөтгөлийн ажлын явц 50 хувьтай байгаа ба ажил гүйцэтгэх гэрээний дагуу 2023 онд ашиглалтад оруулахаар ажиллаж байна. Хэрэгжих хугацаа: 2020-2023 он Нийт төсөвт өртөг–52,0 тэрбум төгрөг 2022 онд санхүүжих дүн–20,0 тэрбум төгрөг | 50% |
| 121 | | 2. Дашбалбар сумын цахилгаан хангамжийн 35 кв-ын цахилгаан дамжуулах агаарын шугам барих ажлыг хэрэгжүүлнэ. | | Ажлын явц, хувиар | 50 | | “Дашбалбар сумын цахилгаан хангамжийн 35кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, 35/10 кВ-ын 1000 КВа чадалтай дэд өртөө барих” 7.3 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй ажлыг улсын төсвийн хөрөнгөөр 2022-2023 онд хэрэгжүүлэхээр 2022 оны Төсвийн тухай хуульд 3.7 тэрбум төгрөг батлагдсаны дагуу гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендер ЭХЯаманд зохион байгуулагдаж, гүйцэтгэгчээр “Энх өглөө” ХХК шалгаран ажил гүйцэтгэх гэрээг | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | байгуулан ажиллаж байна. Ажлын явц 50 хувьтай байгаа ба ажил гүйцэтгэх гэрээний дагуу 2023 онд ашиглалтад оруулахаар ажиллаж байна. Хэрэгжих хугацаа: 2022-2023 он Нийт төсөвт өртөг–7,3 тэрбум төгрөг 2022 онд санхүүжих дүн–3,7 тэрбум төгрөг | |
| 122 | 3.5.2. Төвлөрсөн сум, суурин газарт дулааны төвлөрсөн эх үүсвэр шинээр барих, шугам сүлжээг өргөтгөх ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлж, дулаан хангамжийн чанар хүртээмж, ард иргэдийн ая тухтай амьдрах нөхцөлийг сайжруулна. | 1. Сумын төв болон Чойбалсан хотын захын гэр хороолол, аялал жуулчлалын бүсрүү ЦДАШ барих, хүчин чадлыг нэмэх, өргөтгөх ажлыг хэрэгжүүлнэ. /Баян-Уул, Хэрлэн, Халхгол, Цагаан-Овоо, Хөлөнбуйр/ | | Өргөтгөсөн сумын тоо | 5 | | Аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр Баяндун суманд ЦДАШ барих ажлыг “Дорнын үндэс” ХХК, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр Цагаан-Овоо суманд ЦДАШ, дэд станц барих ажлыг “Дорсүхэ” ХХК, Баян-Уул суманд ЦДАШ, дэд станц барих ажлыг “Техникийн цогц шийдэл” ХХК, Хөлөнбуйр суманд ЦДАШ, дэд станц барих ажлыг “Дорнын үндэс” ХХК, Хэрлэн сумын 3 дугаар багт ЦЭХ-ний дэд станц барих ажлыг “Дорнын үндэс” ХХК тус тус шалгаран ажил гүйцэтгэх гэрээ байгуулан ажиллаж, ашиглалтад оруулсан. Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр Хэрлэн сумын 11 дүгээр багт ЦЭХ-ний дэд станц барих ажлыг “Дорсүхэ” ХХК ажил гүйцэтгэх гэрээ байгуулан гүйцэтгэж байгаа ба ажил 2023 онд үргэлжлэн хэрэгжинэ. | 90% |
| 123 | 3.5.3. Төвлөрсөн сум, суурин газарт дулааны | 1. Сумын төвд төвлөрсөн халаалтын зуух, | | Төвлөрсөн дулааны шугам сүлжээ, халаалтын | 5 | | “Тэргүүн хараат” ХХК 2021 онд Чулуунхороот сумын төвийг төвлөрсөн халаалтын зуух, | 30% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | төвлөрсөн эх үүсвэр шинээр барих, шугам сүлжээг өргөтгөх ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлж, дулаан хангамжийн чанар хүртээмж, ард иргэдийн ая тухтай амьдрах нөхцөлийг сайжруулна. | инженерийн шугам сүлжээ барих ажлыг улсын төсөв, төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд зохион байгуулна. /Хөлөнбуйр, Дашбалбар/ | | зуух баригдсан сумын тоо | | | инженерийн шугам сүлжээнд холбох ажлыг гүйцэтгэж, ашиглалтад оруулсан. 2022 онд тус аж ахуйн нэгжээс концессын гэрээний дагуу Хөлөнбуйр, Цагаан-Овоо сумдыг төвлөрсөн халаалтын зуух, шугам сүлжээнд холбохоор төлөвлөсөн боловч “Тэргүүн хараат” ХХК-ийн хөрөнгө санхүүгийн хүндрэлийн улмаас ажил хойшлогдож, Цагаан-Овоо суманд ажил эхэлсэн. Хөлөнбуйр суманд ирэх оноос ажлыг эхлүүлэхээр төлөвлөж байна. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар “Сумын хөгжил” төслийн хүрээнд Дашбалбар сумын төвд төвлөрсөн халаалтын зуух, инженерийн шугам сүлжээ барих ажлын гүйцэтгэгчээр “Чандмань тал” ХХК шалгаран гэрээ байгуулан ажиллаж байгаа ба ажил гүйцэтгэх графикийн дагуу энэ оны ажил хийгдэж дууссан. Ажлын явц 40 хувьтай, ажил ирэх онд үргэлжлэн хэрэгжинэ. | |
| 124 | 3.5.4. Эрчим хүчний хэмнэлт, үр ашгийг дээшлүүлэх, алдагдлыг бууруулах инновац, шинэ техник | 1. Гэр хорооллын айл өрхүүдэд цагийн ялгавартай тоолуур нэвтрүүлэх замаар шөнийн цахилгааны үнийг хөнгөлөх, чөлөөлөх | | Цагийн ялгавартай тоолуур бүхий айл өрхийн тоо | 100-аар нэмэгдэнэ. | | Цагийн ялгавартай өрхийн тоо 700 болж 104-өөр нэмэгдсэн байна. | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | технологи нэвтрүүлнэ | ажлыг зохион байгуулна. | | | | | | |
| 125 | 3.6.1. Эдийн засгийн өсөлтийг хангах экспортыг нэмгэдүүлэх зам тээврийн сүлжээг өргөжүүлнэ. | 1. Хил орчмын аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор Чойбалсан-Хавиргын хилийн боомтын чиглэлийн 124.5 км хатуу хучилттай автозам барих ажилд орон нутгийн зүгээс дэмжлэг үзүүлэн хамтарч ажиллана. | | Замын ажлын явц | 20 | | Чойбалсан-Хавиргын хилийн боомтын чиглэлийн 124.5 км хатуу хучилттай автозам барих ажлыг 2022-2025 онд хэрэгжүүлэхээр 2022 оны Төсвийн тухай хуульд батлагдсаны дагуу гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг ЗТХЯамнаас зохион байгуулж, тендер шалгаруулалтыг 4 удаа зарласан боловч санал ирүүлсэн оролцогчгүй байсан. 2023 оны улсын төсвийн тухай хуульд батлагдсан. Хэрэгжих хугацаа: 2022-2025 он Нийт төсөвт өртөг–114,0 тэрбум төгрөг 2022 онд санхүүжих дүн–20,8 тэрбум төгрөг | 50% |
| 126 | | 2. Баян-Уул-Ульхан боомт чиглэлийн хатуу хучилттай автозамын барилга угсралтын ажилд орон нутгийн зүгээс дэмжлэг үзүүлж хамтарч ажиллана. | | Замын ажлын явц | 20 | | Баян-Уул сумаас Ульхан боомт хүртэлх 50 км хатуу хучилттай автозам барих ажлыг 2022-2024 онд хэрэгжүүлэхээр 2022 оны Төсвийн тухай хуульд батлагдсаны дагуу гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг ЗТХЯамнаас зохион байгуулж, тендер шалгаруулалтыг 5 удаа зарласан боловч шаардлага хангасан оролцогчгүй байсан. 2023 оны улсын төсвийн тухай хуульд батлагдсан. Хэрэгжих хугацаа: 2022-2024 он Нийт төсөвт өртөг–49,8 тэрбум төгрөг 2022 онд санхүүжих дүн–10,5 тэрбум төгрөг | 50% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 127 | 3.6.2. Байгаль орчинд ээлтэй, эрэлтэд нийцсэн тогтвортой, хүртээмжтэй, аюулгүй тээврийн үйлчилгээг хөгжүүлнэ. | 1. Чойбалсан-Улаанбаатар чиглэлийн улсын чанартай авто зам дагуу  Хөлөнбуйр сумын нутагт зорчигч жуулчдад зориулсан түр буудаллах газрын тохижилтын ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ. | | Тээврийн хэрэгслийн зогсоол, талбай байгуулах ажлын явц /хувь/ | 100 | | Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр Хөлөнбуйр сумын нутаг дэвсгэрт хэрэгжих “Өндөрхаан-Чойбалсан чиглэлийн авто зам дагуу түр буудаллах цэгийн гадна тохижилт, авто зогсоол байгуулах” ажлыг “Дорнод автозам” ХХК ажил гүйцэтгэх гэрээний дагуу гүйцэтгэж ашиглалтад хүлээлгэн өгсөн. | 100% |
| 128 | 3.7.1. Орчин үеийн мэдээлэл, харилцаа холбооны дэд бүтцийг хөгжүүлж, мэдээлэл холбооны үйлчилгээг иргэн, байгууллага, аж ахуйн нэгж бүрт хүргэх нөхцөлийг бүрдүүлнэ. | 1. Шилэн кабелийн сүлжээнд холбогдоогүй сумдыг шилэн кабелд холбож харилцаа холбооны чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ. /Чулуунхороот, Халхгол сум/ | | Шилэн кабелиар холбогдсон сумын тоо | 14 | | “МХС” ТӨХХК өөрийн хөрөнгөөр Баянхошуу хилийн боомтоос Халхгол сумын төв хүртэл 65 км шилэн кабель барьж ашиглалтад оруулсан байна. | 50% |
| 129 | | 2. Сумдын төвийн үүрэн холбооны сүлжээний цамхгуудыг стандартын дагуу барих ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, сүлжээний тархалтыг сайжруулна. | | Стандартын дагуу барьсан цамхгийн тоо | 9 | | Баяндун, Гурванзагал сумдад үүрэн холбооны сүлжээний цамхаг баригдаж ашиглалтад орсон.  Мөн Чойбалсан, Баян-Уул суманд нэмж 2 цамхаг барих саналыг “МХС” ТӨХХК-д хүргүүлсэн. | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 130 | 3.8.1. Газрын харилцааны багц хуулийн хэрэгжилтийг хангаж аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг мөрдөж ажиллана. | 1. Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, Булган, Матад, Хөлөнбуйр сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг хүлээн авах, батлуулах ажлыг зохион байгуулна. | | Батлагдсан төлөвлөгөөний тоо | 9 | | Даян дэлхийн байгаль орчны сангийн буцалтгүй тусламжийн санхүүжилтээр Байгаль орчин, аялал жуулчлалын яам, НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага, Дэлхийн байгаль хамгаалах сангаас хамтран хэрэгжүүлж буй “Дорнод Монголын хуурай хээрийн тогтвортой ландшафт, биологийн олон янз байдлын хамгаалал” төслийн хүрээнд Дорнод аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг шинэчлэх болон Булган, Матад, Хөлөнбуйр сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг боловсруулах ажлын гүйцэтгэгчээр “Геоботаник” ХХК шалгаран ажиллаж байна. Ажил гүйцэтгэх гэрээний дагуу хээрийн болон суурин судалгааны ажил, аймаг, сумдад хийгдэх хэлэлцүүлгийн ажлууд хийгдэж дуусан төлөвлөгөөний төслийг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газарт хянуулах ажил хийгдэж байна. Ажлын явц 90 хувьтай байна. | 90% |
| 131 | | 2. Өвөлжөө, хаваржааны газрын хэмжилт зураглалыг хийж газрын кадастрын мэдээллийн санд | | Эзэмшүүлсэн өвөлжөө хаваржааны тоо | 1400 | | Аймгийн хэмжээнд 130 га газрыг сумдын Засаг даргын захирамжаар эзэмшүүлэх ажил хийгдэж, газрын кадастрын мэдээллийн санд бүртгэн газар эзэмших гэрээ байгуулж, гэрчилгээ олгосон байна. | 70% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | оруулах ажлыг зохион байгуулна. | | | | | | |
| 132 | | 3. Газар эзэмшүүлэх, ашиглуулах, өмчлүүлэх дуудлага худалдааг газрын биржийн цахим систем /www.mle.mn/-ээр зохион байгуулна. | | Цахимаар явагдсан эсэх | 1 | | Газар эзэмших эрхийн гэрчилгээний дуудлага худалдааг цахим биржээр дамжуулан зохион байгуулж байна. Тайлант хугацаанд сумдын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсан нийт 64 байршилд дуудлага худалдааг зохион байгуулж, 31 байршилд ялагч тодрон 151,4 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна. | 100% |
| 133 | | 4. Газрын төлөв байдал чанарын хянан баталгаа хийлгэх ажлыг хэрэгжүүлнэ. | | Ажил хэрэгжсэн эсэх | 1 | | Аймгийн орон нутгийн төсвийн 30,0 сая төгрөгийн хөрөнгөөр Хэрлэн сумын нутаг дэвсгэр дэх мониторингийн байнгын хяналтын 8 цэг, эвдрэлд өртсөн 4 байршил бүхий 350 га талбайн газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны хээрийн судалгааны ажлыг “АТТП” ХХК хийж гүйцэтгэсэн. | 100% |
| 134 | | 5. Тухайн жилд иргэнд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар өмчлүүлэх газрын хэмжээ, байршил, зориулалтыг сумдаас авч нэгтгэн аймгийн ИТХ-аар хэлэлцүүлж, ГЗБГЗЗГ-т хүргүүлэх, эрх бүхий | | өмчлүүлсэн газрын хэмжээ /га/ | 4512 | | Иргэнд 2022 онд өмчлүүлэх газрын байршил, хэмжээ, зориулалтыг баталсан сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолыг нэгтгэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулан хэлэлцүүлж, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 02 дугаар тогтоолоор батлуулан Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газарт хүргүүлсэн. Тайлант | 70% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Засаг даргын захирамжаар иргэнд газар өмчлүүлэх ажлыг зохион байгуулна. | | | | | хугацаанд аймгийн хэмжээнд 1403 иргэнд 143 га газрыг өмчлүүлэхээр төлөвлөсөн ба хөдөөгийн сумдад иргэний гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар . . . иргэнд . . . га газрыг өмчлүүлээд байна. Аймгийн төв Хэрлэн суманд газар өмчлөх хүсэлт гаргасан 350 иргэний хүсэлтийг шийдвэрлэхээр ажиллаж байна. | |
| 135 | | 6. Иргэн, аж ахуйн нэгж байгууллагын газрын төлбөр, татварыг аймгийн төсөвт төвлөрүүлэх ажлыг хэрэгжүүлнэ. | | Төлөвлөгөөний хэрэгжилт, хувиар | 100 | | Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын ашиглаж, эзэмшиж, өмчилж буй газрын татвар, төлбөрийн нэхэмжлэлийг хуульд заасан хугацаанд буюу 02 дугаар сарын 10-ны өдрийн дотор үүсгэж аймгийн Татварын хэлтэст хүргүүлсэн. Мөн улсын хэмжээнд газрын кадастрын системд нөхөн бүрдүүлэлтийн ажил хийгдэж байгаатай холбогдуулан нөхөн бүртгэсэн нэгж талбаруудын татвар, төлбөрийн нэхэмжлэлийг цаг тухай бүрт нь үүсгэн ажиллаж байна. | 70% |
| 136 | 3.8.2. Зүүн бүсийн төв Чойбалсан хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна. | 1. Ивээл хорооллын дахин төлөвлөлтийн ажлын зураг төсөл боловсруулах | | Зураг төслийн тоо | 1 | | Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн 60,0 сая төгрөгийн хөрөнгөөр “Ивээл хорооллын дахин төлөвлөлтийн зураг төсөл боловсруулах” ажлын гүйцэтгэгчээр “Нарт дизайн” ХХК шалгаран гэрээ байгуулан ажиллаж байна. Зураг төсвийг магадлалаар хянуулах ажлаас шалтгаалан ажил гүйцэтгэх гэрээг сунгасан, зураг төсвийг | 50% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | магадлалаар хянуулан 2023 онд хүлээлгэн өгнө. | |
| 137 | | 2. Чойбалсан хотын 2, 3 дугаар багийн нутаг дэвсгэрт аялал жуулчлалын бүс байгуулах ажлын зураг төсөл боловсруулах | | Зураг төслийн тоо | 1 | | Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн 50,0 сая төгрөгийн хөрөнгөөр “Чойбалсан хотын 2, 3 дугаар багийн нутаг дэвсгэрт аялал жуулчлалын бүс байгуулах, хэсэгчлэн төлөвлөлт” ажлын гүйцэтгэгчээр “Нарт дизайн” ХХК шалгаран гэрээ байгуулан ажиллаж байна. Зураг төсвийг магадлалаар хянуулах ажлаас шалтгаалан ажил гүйцэтгэх гэрээг сунгасан, зураг төсвийг магадлалаар хянуулан 2023 онд хүлээлгэн өгнө. | 50% |
| 138 | 3.8.3. Төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан иргэдийг орон сууцтай болоход дэмжлэг үзүүлж, орон сууцны хороолол барих ажлыг Чойбалсан хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд нийцүүлэн хэрэгжүүлнэ. | 1. Чойбалсан хотод шинээр баригдах 1800 айлын орон сууцны хорооллын цахилгаан хангамж, инженерийн шугам сүлжээ барих ажлыг эхлүүлнэ. | | Ажлын явц, хувиар | 10 | | Шинээр баригдах 1800 айлын орон сууцны хорооллын дотор цахилгаан, дулаан хангамжийн зураг төсөв боловсруулах ажлыг “Гидродизайн инноваци” ХХК гүйцэтгэж, 2022 оны улсын төсөвт хорооллын цахилгаан хангамж, инженерийн шугам сүлжээ барих ажлын зардалд 9,8 тэрбум төгрөг батлагдсан. Ажлын гүйцэтгэгчээр “Саруул өргөө констракшн” ХХК шалгаран ажиллаж байгаа ба ажлын явц 60 хувьтай байна. Хэрэгжих хугацаа: 2022-2024 он Нийт төсөвт өртөг–9,8 тэрбум төгрөг 2022 онд санхүүжих дүн-960,0 сая төгрөг | 70% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 139 | | 2. Чойбалсан хотод шинээр баригдах 1000 айлын орон сууцны хорооллын доторх инженерийн шугам сүлжээний ажлын зураг төсвийг хүлээн авч, инженерийн шугам сүлжээ барих ажлыг улс орон нутгийн төсвөөр хэрэгжүүлэх саналыг холбогдох газарт хүргүүлэх ажлыг зохион байгуулна. | | Зураг төслийн тоо | 5 | | 1800 айлын орон сууцны хорооллын дотор цахилгаан, дулаан хангамжийн зураг төсөв боловсруулах ажлыг “Гидродизайн инноваци” ХХК ажил гүйцэтгэх гэрээний дагуу гүйцэтгэж, цахилгааны ажлын зураг төсвийг хүлээлгэн өгсний дагуу 2022 оны улсын төсөвт 960,0 сая төгрөг батлагдаж ажил эхэлсэн. Дулаан хангамжийн ажлын зураг төсвийг хүлээн авч, 2023 оны улсын төсөвт хөрөнгийг тусгуулах саналыг хүргүүлсэн. Хорооллын цэвэр, бохир ус, мэдээлэл холбоо, үерийн ус зайлуулах шугам сүлжээний зураг төсөв боловсруулах ажлыг “Их мянган инженерчлэл” ХХК гэрээ байгуулан ажиллаж байгаа ба ажлын явц 90 хувьтай байна. Зураг төсвийг магадлалаар хянуулах ажлаас шалтгаалан ажил гүйцэтгэх гэрээг сунгасан, зураг төсвийг магадлалаар хянуулан 2023 онд хүлээлгэн өгнө. | 50% |
| 140 | | 3. Орон сууцны хангамжийг нэмэгдүүлэх хүрээнд нийтийн орон сууцны барилга барих ажлыг дэмжиж ажиллана. | | Ашиглалтад орсон орон сууцны тоо | 1300 | | Хувийн хөрөнгө оруулалтаар Хэрлэн сумын 4 дүгээр багийн нутаг дэвсгэрт төмөр бетон каркас хийц бүтээцтэй доороо үйлчилгээний талбай бүхий 45 айлын орон сууцны барилга, 6 дугаар багт 60 айлын орон сууцны барилга, 7 дугаар багт 51, 52 дугаар байрны урд 24 айлын орон сууцны барилга, нийт 129 айлын 3 орон сууц | 70% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | ашиглалтад орсон. Мөн Хэрлэн сумын 2 дугаар багт “Тод сүндрэл” ХХК-ийн захиалгаар 30 айлын 2 орон сууц, 11 дүгээр багт “Дорнод хийц” ХХК-ийн захиалгаар 48 айлын 2 орон сууц, 6 дугаар багт "Марч констракшн" ХХК-ийн 222 айлын 3 орон сууцны "Тана апартмент" хотхон, "Lux town" хотхоны 280 айлын 8 орон сууцны барилга, иргэн Б.Энх-Эрдэнийн 40 айлын орон сууцны болон худалдаа үйлчилгээний төвийн барилга, "Марс" хотхоны 2 дугаар ээлжийн 72 айлын орон сууцны барилгын барилга угсралтын | |
| 141 | 3.8.4. Улс, орон нутгийн төсвөөр хийгдэж буй хөрөнгө оруулалтын ажлыг хэрэгжүүлнэ. | 1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй барилга байгууламжийн ажилд хяналт тавьж, ашиглалтад хүлээн авах ажлыг зохион байгуулна. | | Ашиглалтад орсон барилга байгууламжийн тоо | 19 | | Аймгийн хэмжээнд улсын төсвийн хөрөнгөөр он дамжин хэрэгжих 24, шинээр хэрэгжих 9, нийт 33 барилга байгууламжийн ажилд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэн ажиллаж байна. Тайлант онд аймгийн хэмжээнд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төмөр бетон гүүр 2, цэцэрлэгийн барилга 3, цэцэрлэгийн барилгын өргөтгөл 1, сумын эрүүл мэндийн төв 1, нийгмийн эрүүл мэндийн төв-1, Соёлын төв 2, Мэргэжлийн хяналтын газрын барилга 1, хорооллын доторх хатуу хучилттай авто зам 1 тус тус шинээр ашиглалтад орж, барилгын | 70% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | засварын ажил 1 хийгдэж дуусан ашиглалтад авсан байна. | |
| 142 | | 2. Аймгийн орон нутгийн төсөв, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих барилга угсралт, засварын ажилд хяналт тавьж ашиглалтад хүлээн авах ажлыг зохион байгуулна. | | Ашиглалтад орсон барилга байгууламжийн тоо | 8 | | Аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжих 31, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих 22, нийт 53 барилга угсралт, засварын төсөл, арга хэмжээнд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэн ажилласан. Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолоор батлагдсан дүрмийн дагуу барилга байгууламжийг байнгын ашиглалтад хүлээн авах комиссыг аймгийн Засаг даргын захирамжаар байгуулан ажиллаж, хэрэгжиж дууссан 44 ажлыг ашиглалтад хүлээн авсан байна. | 100% |
| 143 | | 3. Аймгийн Засаг даргын Тамгын газрын барилгын ажлыг дуусган, ашиглалтад хүлээн авах ажлыг зохион байгуулна. | | ашиглалтад орсон эсэх | 1 | | “Аймгийн Засаг даргын тамгын газрын барилгын /Дорнод, Чойбалсан сум/” ажилд 2022 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 3,1 тэрбум төгрөг батлагдсаны дагуу барилга угсралтын ажлыг “Ган хийц” ХХК ажил гүйцэтгэх гэрээг сунган гүйцэтгэж байгаа бөгөөд ажил гүйцэтгэх гэрээний дагуу 2022 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор ажлыг дуусган ашиглалтад хүлээлгэн өгөхөөр ажиллаж байна. Ажлын явц 95 хувьтай. | 90% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 144 | | 4. Усан бассейн бүхий спорт цогцолбор байгуулах ажлын явцад хяналт тавьж ажиллана. | | Ажлын явц, хувиар | 50 | | Усан бассейн бүхий спорт цогцолборын барилгын /Дорнод, Хэрлэн сум/” ажлыг хэрэгжүүлэхээр 2022 онд улсын төсөвт 4,2 тэрбум төгрөг батлагдаж барилга угсралтын ажлыг “Эх бүрдэн” ХХК ажил гүйцэтгэх гэрээний дагуу гүйцэтгэж байна. Ажлын явц 40 хувьтай. Хэрэгжих хугацаа: 2021-2023 он Нийт төсөвт өртөг – 11,9 тэрбум 2022 онд санхүүжих дүн-2,5 тэрбум төгрөг | 70% |
| 145 | | 5. Эрүүл мэнд, боловсрол, соёлын салбарын барилга байгууламжийг засварлах, өргөтгөх ажлыг хэрэгжүүлнэ. | | Засварласан объектын тоо | 23 | | Тайлант хугацаанд эрүүл мэндийн салбарын барилга байгууламжийн засварын 5, боловсролын салбарын барилга байгууламжийн засварын 19, соёлын салбарын барилга байгууламжийн засварын 4, нийт 28 төсөл, арга хэмжээнд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэн ажиллаж, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолоор батлагдсан дүрмийн дагуу барилга байгууламжийг байнгын ашиглалтад хүлээн авах комиссыг аймгийн Засаг даргын захирамжаар байгуулан ажиллаж, хэрэгжиж дууссан 24 ажлыг ашиглалтад хүлээн авсан байна. | 100% |
| 146 | | 6. Хэрлэн сумын 4, 8, 11 дүгээр багт "Ахмадын чөлөөт цагийн төв"-ийн | | Ажлын явц, хувиар | 40 | | “Аймгийн 2022 оны төсөвт нэмэлт өөрчлөлт оруулах тухай” аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 06 дугаар сарын 24-ний | 0% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | барилга барих ажлыг эхлүүлнэ. | | | | | өдрийн 10/02 дугаар тогтоолоор хасагдсан. | |
| 147 | | 7. "Чойбалсан хөгжил" ОНӨҮГ-ын нэгдсэн авто граж барих ажлыг хэрэгжүүлнэ. | | Ажлын явц, хувиар | 40 | | “Аймгийн 2022 оны төсөвт нэмэлт өөрчлөлт оруулах тухай” аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн 10/02 дугаар тогтоолоор хасагдсан. | 0% |
| 148 | | 8. Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын барилгыг засварлана. | | Ажлын явц, хувиар | 100 | | “Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын барилгын засвар” ажлыг “Чимэргү” ХХК ажил гүйцэтгэх гэрээний дагуу гүйцэтгэж, ашиглалтад хүлээлгэн өгсөн. | 100% |
| 149 | | 9. Баяндун, Халхгол суманд нисэх онгоцны буудал барих ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ. | | Ажлын явц, хувиар | 50 | | “Аймгийн 2022 оны төсөвт нэмэлт өөрчлөлт оруулах тухай” аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн 10/02 дугаар тогтоолоор хасагдсан. | 0% |
| 150 | | 10. Улс, орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөрөөр хэрэгжих бүтээн байгуулалтын ажлыг хэрэгжүүлэхэд эзэмшил, ашиглалт, өмчлөлийн газар нь давхацсан иргэн, аж ахуйн нэгжийн газрыг чөлөөлөх, нөхөн олговор олгох | | Газар чөлөөлсөн байршлын тоо | 5 | | Аймгийн Засаг даргын 2022 оны А/74 дүгээр захирамжаар ажлын хэсэг байгуулагдаж Дорнод аймгийн Хэрлэн сумын 4 дүгээр багийн нутаг дэвсгэрт “Багийн ажлын албаны байр болон багийн ахмадын чөлөөт цагийн төв” барих боломжтой газрын байршлыг тогтоож, газрын үнийн судалгааг хийж, 3 байршлийн иргэний өмчлөлийн 750 м2 газрыг нөхөн олговортойгоор авах асуудлыг ажлын хэсгийн хурлаар | 70% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | ажлыг зохион байгуулна. | | | | | шийдвэрлэж холбогдох шийдвэрийг гаргуулан газрыг чөлөөлсөн. | |
| 151 | | 11. Хэрлэн суманд байрлах Зөвлөлтийн нисгэгчдийн хөшөө болон Халхгол сумын Ялалт хөшөөг засварлах, Хэрлэн сумын Монгол дайчдын хөшөө, Сэргэлэн сумын Сэнжит хадны тохижилт, Чулуунхороот сумын Гурван улсын "0" баганын тохижилтын ажлыг хэрэгжүүлнэ. | | Ажлын явц, хувиар | 100 | | Халхгол сумын Ялалт хөшөөг засварлах ажлыг “Хүннү арт дизайн” ХХК гүйцэтгэсэн. Чулуунхороот суманд байрлах “Гурван улсын "0" баганын тохижилт”-ын ажлыг шууд гэрээ байгуулан гүйцэтгүүлэх Үнэлгээний хорооны дүгнэлт гарч, аж ахуйн нэгжүүдээс үнийн санал авах ажил хийгдэж байна. Хэрлэн суманд байрлах “Зөвлөлтийн нисгэгчдийн хөшөө”-г засварлах, Сэргэлэн суманд байрлах “Сэнжит хадны тохижилт” ажлууд төсвийн тодотголоор хасагдсан. | 70% |
| 152 | | 12. Булган суманд "Чингис хааны хар сүлд тахилгын байгууламж", Халхгол суманд "То вангийн өв соёлын өргөө" барих ажлыг эхлүүлнэ. | | Ажлын явц, хувиар | 50 | | “Аймгийн 2022 оны төсөвт нэмэлт өөрчлөлт оруулах тухай” аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн 10/02 дугаар тогтоолоор хасагдсан. | 0% |
| 153 | | 13. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нөхөн сэргээх төвийн гадна инженерийн | | Ажлын явц, хувиар | 100 | | Зураг төсвийг шинэчлүүлэх шаардлага гарсны дагуу зураг төсвийг шинэчлэх ажил хийгдэж, магадлалаар хянагдсан. Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендер зарлагдсан, 12 дугаар | 50% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | шугам сүлжээ барих ажлыг хэрэгжүүлнэ. | | | | | сарын 02-ны өдөр нээнэ. Ажил ирэх онд үргэлжлэн хэрэгжинэ. | |
| 154 | | 14. Дорнод аймагт 2023 онд хэрэгжүүлэхээр төлөвлөж буй хөрөнгө оруулалтын барилга байгууламж, тохижилт, их засварын ажлын зураг төсвийг боловсруулах ажлыг хэрэгжүүлнэ. | | Ажлын явц, хувиар | 19 | | 1.Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар “Хэрлэн сумын 5 дугаар баг руу 35 кв-ын цахилгаан дамжуулах агаарын шугам барих” ажлын зураг төсөв боловсруулах ажлыг “Перфект солюшн инженеринг” ХХК, 2.“Сур харвааны цогцолбор байгуулах” ажлын зураг төсвийг “Талын хас констракшн” ХХК, 3.“Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн амбулаторийн тасгийн барилгыг орон сууцны зориулалттай болгон засварлах” ажлын зураг төсвийг “Тэмжин” ХХК, 4.“Сүүний үйлдвэр байгуулах техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв боловсруулах” ажлыг “Талын хас констракшн” ХХК, 5.Хөлөнбуйр суманд “Мал эмнэлгийн хорио цээр, ариутгал халдваргүйтгэлийн хяналтын цэг байгуулах” ажлын зураг төсвийг “Талын хас констракшн” ХХК, 6.“Чойбалсан хотын ус хангамжийн шугам сүлжээг шинэчлэх” ажлын зураг төсвийг “Гидродизайн инноваци” ХХК, 7.“Дулаан, цэвэр, бохир усны шугамын өргөтгөл (Хэрлэн сум, 4-р баг)” ажлын зураг төсвийг “Талын хас констракшн” ХХК, 8.Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар “Хэрлэн сумын 6 | 70% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | дугаар баг, Ивээл хорооллын дахин төлөвлөлт хийх”, 9.“Чойбалсан хотын 2, 3 дугаар багийн нутаг дэвсгэрт аялал жуулчлалын бүс байгуулах хэсэгчилсэн төлөвлөлт хийх” ажлуудыг “Нарт дизайн” ХХК, 10.“Чойбалсан хотын төвлөрсөн хогийн цэг байгуулах” ажлын зураг төсвийг “Мишээл кристал хаус” ХХК, 11.“Хэрлэн голын 217,6 у/м төмөр бетон гүүрийн барилга угсралтын ажлын зураг төсөв, магадлалын ажил”-ыг “ХЗТ-Автозам” ХХК, 12.Хэрлэн сумын 3 дугаар багт баригдах “1800 айлын орон сууцны хорооллын доторх инженерийн шугам сүлжээ (цахилгаан, дулаан)-ний ажлын зураг төсөл боловсруулах” ажлыг “Гидродизайн инноваци” ХХК ажлын зураг төсвийг хүлээн аваад байна. | |
| 155 | | 15. Хэрлэн сумын 10 дугаар байрны хүчитгэл бэхэлгээний ажлын дүгнэлт гаргуулж, засварын ажлыг зураг төсвийг хийлгэх ажлыг зохион байгуулна. | | Ажил хэрэгжсэн эсэх | 1 | | “Нийтийн орон сууцны 10 дугаар байрны хүчитгэл бэхэлгээний ажлын дүгнэлт гаргуулах” зөвлөх үйлчилгээний ажлыг “Бүүвэй цагаан барс” ХХК-аар гүйцэтгүүлж, дүгнэлтийг хүлээн авсан. Мэргэжлийн байгууллагаас гаргасан дүгнэлтийг үндэслэн нийтийн орон сууцны 10 дугаар байрны барилгын хүчитгэл бэхэлгээний ажлын зураг, төсөв боловсруулах ажлыг “ДОЗТ” БГБХН | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | гэрээ байгуулан гүйцэтгэж хүлээлгэн өгсөн. | |
| 4. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО | | | | | | | | |
| 156 | 4.1.2. Төрийн албан хаагчийг чадавхжуулж, тогтвортой ажиллах нөхцлөөр хангана. | 1. Төрийн байгууллагуудын албан хаагчдын ажлын ур чадвар, ёс зүй, харилцаа хандлагад иргэд шууд үнэлгээ өгөх нэгдсэн системийг нэвтрүүлнэ. | | Систем нэвтрүүлсэн эсэх | 1 | | Дорнод аймгийн Засаг даргын тамгын газар, Засгийн газрын хэрэг эрхлэх газар, МУ-ын Төрийн албаны зөвлөл хамтран аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд агентлаг болон сумдын Засаг даргын тамгын газрын Ёс зүйн зөвлөлийн дарга, нарийн бичгүүдэд Төрийн албан хаагчдын ёс зүйн зөвлөгөөнийг 2022 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр зохион байгуулсан.  Байгууллагын нөөц боломжид тулгуурлан албан хаагчдын ёс зүй, харилцаа хандлагад иргэд шууд үнэлгээ өгөх системийг 1 сум, 1 агентлагт нэвтрүүлсэн байна. | 70% |
| 157 | | 2. Орон нутгийн мэргэжил олгох сургуулиудыг түшиглэн төрийн албан хаагчдын ур чадварыг нэмэгдүүлэх зорилгоор сургалтыг үе шаттай зохион байгуулна. | | Зохион байгуулах сургалтын тоо | 5 | | Төрийн албан хаагчдыг ажлын байранд нь сургах, чадавхжуулах, орон нутагт нь мэргэшил дээшлүүлэх, боловсрол эзэмшихэд ажлын цагийн хөнгөлөлт үзүүлэх, цалинтай чөлөө олгох, төлбөрийн уян хатан нөхцөл үзүүлэх, сум орон нутагт нь багш нар очиж хичээл заах зэргээр хамтран ажиллаж дэмжлэг үзүүлснээр Дорнод их сургуулийн бакалавр, магистрийн сургалтад сум, агентлагийн нийт 70 | 70% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | гаруй албан хаагч хамрагдаж байна. | |
| 158 | | 3. Төрийн байгууллагын үйл ажиллагаа, хүний нөөцийн бодлого, бараа, ажил үйлчилгээ худалдан авах, төсөв санхүүгийн ил тод, нээлттэй байдлын шалгуур үзүүлэлтүүдийг хангаж ажиллана. | | Ил тод байдлын үнэлгээний хувиар | 100 | | Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 17 дугаар “Төрийн жинхэнэ албаны нөөц бүрдүүлэх журам, загвар батлах тухай” тогтоолын дагуу байгууллага бүр төрийн жинхэнэ албанаас чөлөөлөгдсөн албан хаагчийн мэдээллийг тухай бүр бүртгэж нөөцийн бүртгэл хөтөлж хяналт тавьж, csc.gov.mn цахим сайтад нөөцийн мэдээллийг байршуулж байна. Мөн энэ жилийн байдлаар хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг 30 албан хаагч хянуулсан. Нийт төрийн байгууллагууд өөрийн албан сайтаар дамжуулан иргэдэд мэдээллийг хүргэн ажиллаж байгаа бөгөөд аймгийн Засаг даргын тамгын газар аймгийн нэгдсэн веб сайт dornod.gov.mn, төсвийн гүйцэтгэлийн хяналтын нэгдсэн систем report.dornod.gov.mn сайтаар дамжуулан аймгийн орон нутгийн болон хөрөнгө оруулалтын явц байдлын талаар мэдээллийг тухай бүр хүргэн ажиллаж байна. Худалдан авах ажиллагааг 100 хувь цахимаар буюу tender.gov.mn сайтаар дамжуулан зарлаж байна. | 100% |
| 159 | | 4. Аймгийн нийт төрийн байгууллагын албан | | Ёс зүйн зөрчлийн тоо | 15 | | 2022 оны байдлаар аймгийн сум, агентлагийн нийт 36 ёс зүйн зөвлөлд арга зүйн дэмжлэг үзүүлэх, | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | хаагчдын сахилга хариуцлага, ёс зүйн зөрчлийн нэгдсэн бүртгэлийг сайжруулж, албан тушаалаа урвуулан ашиглах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлнэ. | | | | | чиглүүлэх үүрэг бүхий “Ёс зүйн хяналтын зөвлөл”-ийг байгуулж, ёс зүйн жилийн төлөвлөгөө батлан ажилласан. Ёс зүйн жилийн төлөвлөгөөний дагуу ёс зүйн зөвлөлийн нарийн бичгийн дарга нарт арга зүйн цахим сургалт, аймгийн ёс зүйн нэгдсэн зөвлөгөөн зэргийг зохион байгуулсан. Тус зохион байгуулалтын арга хэмжээнд сум, агентлаг, боловсрол, эрүүл мэнд, хилийн цэрэг, зэвсэгт хүчин зэрэг байгууллагын 500 гаруй албан хаагчид хамрагдсан. Аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг, сумдад нийт 4 албан хаагч ёс зүйн зөрчилд холбогдсоныг тухай бүр шийдвэрлэн ажиллаж, аймгийн Засаг даргын тамгын газар, сум, агентлагууд ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх 12 удаагийн сургалтад 500 гаруй албан хаагчдыг хамруулсан байна. Өмнөх жилийн мөн үетэй харьцуулахад ёс зүйн зөрчил мэдээлэл 66 хувиар буурсан байна. | |
| 160 | | 5. Төрийн байгууллагуудын ёс зүйн зөвлөлийн үйл ажиллагааг идэвхжүүлж, хараат бусаар шийдвэр гаргах боломжийг бүрдүүлж ажиллана. | | Ёс зүйн зөвлөлийн тоо | 32 | | 2022 оны байдлаар аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг, сумдад нийт 4 албан хаагч ёс зүйн зөрчилд холбогдсоныг тухай бүр шийдвэрлэн ажиллаж, аймгийн Засаг даргын Тамгын газар, сум, агентлагууд ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх 12 удаагийн | 70% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | сургалтад 500 гаруй албан хаагчдыг хамруулсан байна. | |
| 161 | | 6. Төрийн албан хаагчийг хөгжүүлэх, тогтвор суурьшилтай ажиллуулах, сургалт хөгжил, нийгмийн баталгааг дэмжих ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ. | | Хэрэгжилт хувиар | 100 | | Хөтөлбөрийн хүрээнд  төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтад бэлтгэгчдэд зориулсан сургалтыг Дорнод их сургууль, агентлагийн дарга нартай хамтран 248 иргэнд зохион байгуулсан. Мөн албан тушаалын тодорхойлолтын хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд “Хүний нөөцийн ажилтны өдөр”-ийг угтаж Дорнод аймгийн Засаг даргын тамгын газраас 2 дахь жилдээ Сумдын болон аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний төрийн албан хаагчдын дунд “Албан тушаалын ур чадварын уралдаан”-ыг амжилттай зохион байгуулж сум, агентлаг тус бүр шагналт байр эзлүүлсэн. Уралдааны үр дүн нь төрийн албан хаагчийн Албан тушаалын тодорхойлолтод заасан ур чадвараа хөгжүүлж, шинийг санаачлан байгууллага, хамт олон, салбартаа манлайлан ажиллах боломжийг бий болгосон. Мөн Удирдлагын академийн мэргэшүүлэх багц сургалтад аймгийн Засаг даргын тамгын газрын болон сум, агентлагийн нийт 44, богино хугацааны мэргэшүүлэх зайн сургалтад 89 албан хаагч хамруулж ажилласан. Аймгийн хүний нөөцийн ажилтныг | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | чадавхжуулах хүний нөөцийн ажилтны клубийн ээлжит уулзалтыг зохион байгуулж Канадын Мерит төсөлтэй хамтран 3 удаагийн уулзалтад 25 агентлагийн хүний нөөцүүдэд сургалт зохион байгууллаа. | |
